
СИТИ SCIENCE

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ СЭТГҮҮЛ

МЭДЛЭГ БОЛ ХҮЧ, ЭРХ ЧӨЛӨӨ - SCIENTIA EST POTENTIA, LIBERTAS



COMPARATIVE ADVANTAGES ANALYSIS OF LEATHER TANNING INDUSTRY AND EXPORTS FROM MONGOLIA

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГААС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ, УР ДҮН

ЗАЛУУЧУУДЫН ЗАН СУРТАХУУНЫ ТӨЛӨВШЛИЙН БАЙДЛЫГ АЖИГЛАХУЙ

МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ХҮНСНЭЭС АВАХ ҮНДСЭН ШИМТ БОДИСЫН СУДАЛГАА

ЖУУЛЧНЫ БААЗУУДЫН УСНЫ ХЭРЭГЛЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

citiuniversity

ISSN 2788-7685 · 2021 ГУРАВДУГААР УЛИРАЛ · www.citi.edu.mn №3

CITI SCIENCE
2021 он №03

1 SH.BATDELGER
The lecturer of Business school of CITI University
D.ARILDII
Business School of National University of Mongolia, master degree student

COMPARATIVE ADVANTAGES ANALYSIS OF LEATHER TANNING INDUSTRY AND EXPORTS FROM MONGOLIA.....4

2 Д.ЦЭВЭЭННАМЖИЛ
Хөдөө, аж ахуйн их сурргуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Статистик-Эконометрикийн тэнхимийн багш, доктор /Ph.D/
Ч.БАТЖАРГАЛ
Хөдөө, аж ахуйн их сурргуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Статистик-Эконометрикийн тэнхимийн багш

МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ХҮНСНЭЭС АВАХ ҮНДСЭН ШИМТ БОДИСЫН СУДАЛГАА ...12

3 Х.АРИУНАА
Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор
О.ОЮУНДАЛАЙ
«СИТИ» Их сургуулийн Барилга, архитектур, дизайны сургуулийн Компьютер, график дизайны тэнхимийн багш

ӨӨРТӨӨ ҮЙЛЧЛЭХ ТЕХНОЛОГИ (SST)-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ НЬ.....20

4 Б.САЙХАНДЭЛГЭР
«СИТИ» Их сургуулийн Бизнесийн сургуулийн Аялал жуулчлалын тэнхимийн III курсийн оюутан

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ (Хустайн байгалийн цогцолборт газрын жишээн дээр хийсэн судалгаа) 31

5 Д.САНДАГСҮРЭН
«СИТИ» Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/

ЗАЛУУЧУУДЫН ЗАН СУРТАХУУНЫ ТӨЛӨВШЛИЙН БАЙДЛЫГ АЖИГЛАХУЙ.....38

6 Б.МӨНХТОГТОХ
«СИТИ» Их сургуулийн Бизнесийн сургуулийн Аялал жуулчлалын багш, магистр
Х.ОЮУНДАРЬ
«СИТИ» Их сургуулийн Бизнесийн сургуулийн Аялал жуулчлалын тэнхимийн IV курсийн оюутан

ЖУУЛЧНЫ БААЗУУДЫН УСНЫ ХЭРЭГЛЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ (Тогтвортой аялал жуулчлалын судалгааны жишээн дээр).....45

Редакцын зурвас

Монгол орны байгаль харьцангуй унаган төрхөө хадгалж үлдсэн боловч уур амьсгалын өөрчлөлт болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүчин зүйлээс хамааран зарим газарт экологийн тэнцэл алдагдах хандлага ажиглагдаж байна. Дэлхийн нийтийн чиг хандлагаас харахад тусгай хамгаалалттай газар нутаг нь биологийн олон янз байдал, байгалийн болон түүх, соёлын өвийг хадгалан хамгаалах, зохистой ашиглах, экосистемийн тэнцэрт байдлыг хангах, байгаль орчны доройтлыг хязгаарлах, хойч үедээ хадгалан үлдээхэд чухал үүрэгтэй болох нь тодорхой байна.

Манай улсын хувьд төрөөс тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг үе шаттай өргөжүүлж, өнөөгийн байдлаар нийт газар нутгийн 21 хувьтай тэнцэх 32.8 сая га талбай бүхий 120 тусгай хамгаалалттай газар байгуулаад байна. Эдгээр тусгай хамгаалалттай газар нутгийг улсын хэмжээнд нийт 34 хамгаалалтын захиргаа хариуцан ажиллаж байгаагийн дотор Хустайн байгалийн цогцолборт газарт сайн жишиг нэгэнт тогтсон байна. Тухайлбал, Хустайн байгалийн цогцолборт газрыг менежментийн гэрээгээр хариуцан ажиллаж байгаа төрийн бус байгууллага санхүүжилтийн асуудлаа өөрийн үйл ажиллагаа, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хүрээнд шийдвэрлэж байгаа нь төрийн ачааллыг бууруулан, байгаль хамгаалалд төр, хувийн хэвшлийн хамтын түншлэл бий болж, орон нутгийн иргэдийн оролцоо, идэвхи нэмэгдэн, хамтарсан хяналт бий нэгэнт бий болжээ.

Хустайн байгалийн цогцолборт газрын менежментийг хэрэгжүүлж буй төрийн бус байгууллага орон нутгийн иргэдтэй хэрхэн хамтран ажиллаж, ямар үр дүн гарсан хийгээд нутгийн иргэдийн амьдралд тэр нь хэрхэн нөлөөлсөн болон иргэдэд тулгарч буй асуудлыг яаж шийдвэрлэж байгаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, менежментийг судлан, таниулсан судалгааны өгүүлэл энэ удаагийн дугаарт нийтлэгдсэн байна.

Ажахуйнзохисгүйүйлажиллагаа, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө экосистемийн төлөв байдал, амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд бодитоор мэдрэгдэж, ховор ан амьтан, ургамлын төрөл зүйл устах, бэлчээр талхлагдан хөрсний үржил шим муудах, цөлжих, ой, усны нөөц хомсдох зэргээр экосистемийн доройтол, цөлжилт илэрхий ажиглагдаж байгаа энэ үед асуудлыг хөндсөн, сайн менежмент, туршлагыг судалсан өгүүлэл нийтлэгдсэнийг Редакцын зүгээс цаг үеэ олсон хэмээн олзуурхан онцолж байна.

Эх орныхоо байгалийн болон түүх, соёлын өвийг хадгалан хамгаалах, зохистой ашиглах, хойч үедээ өвлүүлэн үлдээх нь өнөө үеийнхний чухал үүрэг болохыг бид ухамсарлаж, дорвитой арга хэмжээ шуурхай авах шаардлагатай байна. Саяхан Шотландын Глазго хотод зохион байгуулагдсан, дэлхийн 100 гаруй улсын төр, засгийн тэргүүн оролцсон Уур амьсгалын тухай НҮБ-ын Суурь конвенцид нэгдэн орсон улс орнуудын бага хурлын 26 дахь чуулганаар ч энэ тухай ярилцаж, хэтэрхий оройтохоос өмнө шийдвэртэй арга хэмжээ авч, өгсөн үүрэг, амлалтуудаа биелүүлбэл уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай гамшиг, сүйрлээс аврагдах боломжтой талаар ярилцаж, тохирсон юм.

Эрхэм уншигч Та бүхэн Сити-Science сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл, бүтээлийн талаарх санал, хүсэлтээ info@citi.edu.mn хаягаар ирүүлээрэй. Бид уншигчдынхаа санал, бодлыг анхаарч ажиллах болно.

Мэдлэг бол Хүч, Эрх чөлөө!
Scientia est Potentia, Libertas!

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

ДАРГА:

Д.Мөнх-Эрдэнэ
/«СИТИ» Их сургуулийн удирдах зөвлөлийн дарга/

ДЭД ДАРГА:

Ц.Байгалмаа
/«СИТИ» Их сургуулийн Ерөнхийлөгч/

ГИШҮҮД:

Д.Энхбат
/Захиргаа, хүний нөөцийн газрын захирал/

Х.Наранхүү
/Сургалтын бодлого, зохицуулалтын газрын захирал/

Т.Сугарсүрэн
/Инновац, бизнес хөгжлийн газрын захирал/

Т.Алтанцэцэг
/Гадаад харилцааны албаны захирал/

Д.Отгонзаяа
/Барилга, архитектур, дизайны сургуулийн захирал/

Г.Алтантовч
/Бизнесийн сургуулийн захирал/

Б.Одонгэрэл
/Хууль зүйн сургуулийн захирал/

И.Ундрахгэрэл
/Хүмүүнлэгийн сургуулийн захирал/

Ч.Дэлгэрцэцэг
/Урлагийн сургуулийн захирал/

Н.Чанцалдулам
/Гоо сайхны сургуулийн захирал/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.Сандагсүрэн
/Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч/

ЭХ БЭЛТГЭСЭН

З.Райымбек
/Мэдээлэл, технологийн газрын захирал/

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн зөвлөл нь дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдэнэ. Уг зөвлөл нь сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, сэтгүүлийг цаашид хөгжүүлэх бодлого, чиглэлийг боловсруулж батлуулах эрхтэй.

https://www.citi.edu.mn/citi-science/

SH.BATDELGER
The lecturer of Business school of CITI University

D.ARILDII
Business School of National University of Mongolia,
master degree student

COMPARATIVE ADVANTAGES ANALYSIS OF LEATHER TANNING INDUSTRY AND EXPORTS FROM MONGOLIA

Abstract

Studies have been conducted on the leather and leather production, known as one of Mongolia's two non-mining products with a comparative advantage, including manufacturing leather production, and government involvement, export promotional policies and investments.

The main purpose of this study is to develop recommendations on possible opportunities and ways to develop the leather tanning industry. Due to reach the objective, identify feature of Mongolia's tanning industry, and distinguishing its characteristics with selected reference countries experiences and study global trends in the industry.

The data required for the study are mainly sourced by the National Statistics Office in Mongolia. Additional data was generated from several interviews and meetings with experts from Leather Manufacturers Association under the Ministry of Food, Agriculture and Light Industry of Mongolia. The statistics of leather tanning industry are obtained from the report on the «Development Strategy on Mongolia Leather Tanning Industry» survey, conducted in 2020. Some data on the domestic market prices of leather products are based on surveys of retailers and consumers.

Most majority of the world-level leather companies are based in Asia. To develop the industry, the government provides soft loans, tax exemptions and investment assistance. Not only government support, but also international development agencies, like United Nations Industrial Development Organization (UNIDO), International Labor Organization (ILO), Food and Agricultural Organization (FAO) and German Agency for Technical Cooperation (GTZ), are supporting through assistant to develop the industry.


Key words

Leather Tanning Industry, PRC – People's Republic of China, Italy, Thailand, India, Turkey, Export, Import

Preface


The main purpose of this study is to develop recommendations on possible opportunities and ways to develop the leather tanning industry. Due to reach the objective, identify feature of Mongolia's tanning industry, and distinguishing its characteristics with selected reference countries' experiences and study global trends in the industry.

Mongolia's exports of raw and processed hides, skins, furs and articles made of them, period 2000 -2020 *(measuring unit: thousand USD)*



Mongolia's exports of raw and processed hides, skins, furs, and articles made of them for last 20 years account for a total of 724,787 thousand USD or which equal to 1% of Mongolia's total exports[1].


Mongolia's imports of raw and processed hides, skins, furs and articles made of them, period 2000 -2020 *(measuring unit: thousand USD)*



Only 0.1% of Mongolia's total imports, equals to 79,759 thousand USD, are raw and processed hides, skins, furs, and articles made of them.

Mongolia's exports of raw and processed hides, skins, furs and articles made of them, by countries, period 2015 -2019 *(measuring unit: thousand USD)*

[1] (Source: https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1400_005V1&GH1_select_all=1&GH1SingleSelect=&YearM_select_all=0&YearMSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020_2019_2018_2017_2016_2015_2014_2013_2012_2011_2010_2009_2008_2007_2006_2005_2004_2003_2002_2001_2000&viewtype=table)



The target markets for Mongolia's raw and processed hides, skins, and fur products are China, Italy, Thailand, India, and Turkey. The graphic in below shows that exports did not increase much, even decreased from 2015 to 2019[2].

Listed below is the reasons for Mongolia's low export output:

- The vast majority of tanned hides are damaged, which not only reduces the value of the final product, but also increases the cost of processing;
- Additionally, the reason mentioned above lead to the conclusion that the competitiveness of tanneries is reduced due to poor quality raw materials.

1.RESULTS OF THE ANALYSIS ON REVEALED COMPARATIVE ADVANTAGE (RCA) INDEXC

Using a Revealed Comparative Advantage (RCA) index to identify which countries could be potential importer of Mongolian leather and raw materials, and how to compete with countries with comparative advantages.

$$RCA_{ij} = \frac{E_{ij}/E_i}{E_{nj}/E_n}$$

The Revealed Comparative advantages index is defined as the ratio of certain country in a certain products' share of the country's total exports , and compare it to the certain products' total global exports.

This theory refers as in below:

- Eij means Mongolian export of raw and processed hides and skins, furs and articles made


[2] (Source: https://www.trademap.org/Country_SelProductCountry_TS.aspx?nvpm=1%7c496%7c%7c%7c%7c41%7c%7c%7c2%7c1%7c1%7c2%7c2%7c1%7c2%7c1%7c1%7c1

of them


- Ei equals to total exports of Mongolia
- Enj refers that Chinese exports of raw and processed hides and skins, fur and articles made of them
- En refers total export of China

Explanation: If the RCA index is greater than 1, the product 'j' is considered to have a comparative advantage and competitiveness in terms of exports to the target market.

The table below compares Mongolia's exports of raw and processed hides and skins, furs, and articles made from them, as well as Mongolia's total exports over the past five years. In addition, the following results were obtained to determine whether Mongolia has a comparative advantage based on export data of the selected countries in below charts for the same period of 2016-2020. *(Please see the result of estimation from the appendix 1)*



From the above graph, it can be concluded that the RCA index of China, Thailand and India is higher than 1, so the above mentioned countries have a comparative advantage and competitiveness in terms of Mongolia's exports of raw and processed hides, skins and furs. On the other hand, Italy and Turkey do not have a comparative advantage regarding Mongolia's export.



Also, considering the comparative advantage of imports, RCA is less than 1 refers that Mongolia not being able to have a comparative advantage in imports of raw and processed hides, furs, and fur products compared to other countries.

The table below shows the relative comparative advantage on leather export from Mongolia to China, the code which start with 41. *(data from 2019 statistics)*

Code	Category	China	Mongolia	RCA index
4105	Processed sheep and lamb skins	21759	1116	21.6748709
4101	Processed hides and skins of cattle and horses, salted, dried and pure	10898	1765	68.4430198
4104	Cattle and horse hairless tanned skins	26256	4503	72.4777395
4106	Processed skins of goats and nannies/bucks	12045	2134	74.8719023

China accounts for the majority or 70% of Mongolia's leather exports in 2019. Therefore, there is a need to determine whether or not each of the four types of leather exports from Mongolia to China has a comparative advantage in the Chinese market. In determining so, RCA can be less that 1 in the classified exports shown in above table. To conclude, these four types of leather exports from Mongolia to China can not have a comparative advantage.


Appendix #1 RCA calculation on exports

Countries	Export	Total	Result	RCA Index
Mongolia	Export of raw and processed hides and skins, fur and articles made of them	83.956	0.003	9.733
	Total Exports	31.878.571		
China	Export of raw and processed hides and skins, fur and articles made of them	3.239.930	0.000	
	Total Exports	11.974.184.471		
Italy	Export of raw and processed hides and skins, fur and articles made of them	19.934.118	0.008	0.337
	Total Exports	2.552.730.246		
Thailand	Export of raw and processed hides and skins, fur and articles made of them	2.989.844	0.003	1.034
	Total Exports	1.174.009.831		
India	Export of raw and processed hides and skins, fur and articles made of them	3.503.32	0.002	1.112
	Total Exports	1.479.563.267		
Turkey	Export of raw and processed hides and skins, fur and articles made of them	994.522	0.001	0.223
	Total Exports	818.051.830		

Appendix #2 RCA calculation on imports

Countries	Imports	Total	Result	RCA Index
Mongolia	Imports of raw and processed hides and skins, fur and articles made of them	7.293	0.000	0.129
	Total Imports	24.280.092		
China	Imports of raw and processed hides and skins, fur and articles made of them	22.571.852	0.002	
	Total Imports	9.689.181.059		
Italy	Imports of raw and processed hides and skins, fur and articles made of them	14.226.200	0.006	0.048
	Total Imports	2.261.440.268		
Thailand	Imports of raw and processed hides and skins, fur and articles made of them	3.035.791	0.003	0.111
	Total Imports	1.120.555.130		
India	Imports of raw and processed hides and skins, fur and articles made of them	2.735.360	0.001	0.237
	Total Imports	2.156.676.532		
Turkey	Imports of raw and processed hides and skins, fur and articles made of them	1.170.283	0.001	0.279
	Total Imports	1.085.309.727		

SWOT Analysis: Mongolia’s leather tanning industry



Recommendation:

1. To open a channel for exporting products and selling products in the domestic market:
   - Improving the quality public procurement;
   - Implement marketing projects for foreign markets.

2. Training and strengthening human resources:
   - Support vocational training and exchange of specialists to abroad;
   - Organizing vocational training /academic and retraining/.

3. Improving product competitiveness
   - Organize the structure and management of laboratories and research institutes;
   - Introduce new technologies to improve the quality of domestically processed leather and improve the design of the final product.

Improving the raw material procurement system and clarifying the roles and responsibilities of the participants in each value-added process, from raw materials to finished products, will enable the process to run smoothly and efficiently. For instance, in the preparation of meat and leather raw materials:

- Carry out herding and slaughtering activities in accordance with technology;
- Herder supply their own raw materials to network which able to deliver directly to the tanneries;
- Promote the herders' active participation in the supply chain to ensure that local people do treatments without compromising quality of raw materials;
- Manufacturers use their full capacity to turn raw materials into finished products;
- Government and non-government, professional organizations (veterinary, standards, accounting and statistics, professional inspection, trade, service, transportation, training, and finance, etc.) to fulfill their responsibilities and cooperate with each other;
- Supply of certain parts of the growing demand in the local and foreign markets.

BIBLIOGRAPHY:

- Mongolian Statistical Information Service: by www.1212.mn. (2019).
- Istanbul Stock Market: by www.borsaistanbul.com. (2019).
- Ministry of Food, Agriculture and Light Industry of Mongolia: by mofa.gov.mn/exp/. (2019).
- Bujinlkham.B. (2015). Financial Management /4th edition/
- Davaasuren.B. C.M.-O.-A. (2015). Preliminary feasibility study for the development of the leather tanning industry, Ulaanbaatar.
- Molomjamts.D. (2015). Financial and economic analysis, Ulaanbaatar.
- Munkhjargal.D. (2014). Opportunities and ways to develop the leather tanning industry. Ulaanbaatar.
- Uyanga (2012). Competitiveness Survey of the Mongolian Leather Tanning Industry, Ulaanbaatar.
- Chimedregzen.U (2009). Historical trajectory of leather research and experimental centers, Ulaanbaatar.
- Mongolia Stock Exchanges. (2015). Sourced from www.mse.mn
- Integrated legal information system. (2018). by
- (http://www.legalinfo.mn/annex/details/5509?lawid=8603)
- Source: Research on the Mongolian leather tanning industry (2020).
- http://local.news.mn/content/144238.shtrml.



"СИТИ" ИХ СУРГУУЛИЙН БҮТЭЭЛИЙН САН

www.data.citi.edu.mn

Д.ЦЭВЭЭННАМЖИЛ
Хөдөө, аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Статистик-Эконометрикийн тэнхимийн багш, доктор /Ph.D/

Ч.БАТЖАРГАЛ
Хөдөө, аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Статистик-Эконометрикийн тэнхимийн багш

МОНГОЛ ХҮНИЙ ХООЛ ХҮНСНЭЭС АВАХ ҮНДСЭН ШИМТ БОДИСЫН СУДАЛГАА

Хураангуй

Хүнсний шимт бодисыг бүрдүүлдэг ууураг, тос, нүүрс усны тухай Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээлэлд тулгуурлан монгол хүний хоол хүнсний хэрэглээний тухай шинжлэх ухааны үндэстэй тайлбар өгөхийг зорьсон. Ингэхдээ уг мэдээллийн онцлог, хүнсний салбарын норм, стандартад нийцэх шинжилгээ хийсэн болно.

Түлхүүр үг

Шим тэжээл, физиологийн норм, дисперс, чанарын үзүүлэлт, түүвэр

Удиртгал

Хоол хүнс нь үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодис болон бичил тэжээлийн бодисуудаас бүрдэнэ. Үндсэн шимт бодис гэдэгт ууураг, тос, нүүрс ус хамаарна. Илчлэг, шим тэжээл гэж бие махбодын өсөн төлжих болон бодисын солилцоонд чухал үүрэгтэй хүнс, хоолны найрлагад агуулагддаг шимт бодисын бүрдлийг хэлнэ. Нүүрс, ус нь цагаан будаа, гоймон, талх зэрэг үр тарианы гаралтай бүтээгдэхүүнд илүү агуулагддаг бөгөөд 1 граммд ногдох илчлэгийн хэмжээ нь 4 ккал байна. Тос нь мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногоо, самар, загас, наранцэцэг, хулуу зэрэг бүтээгдэхүүнд агуулагддаг бөгөөд 1 граммд ногдох илчлэгийн хэмжээ нь 9 ккал байна. Ууураг нь мах, дүүпүү, шар буурцаг, өндөг, үр тариа, цагаан идээ, сүү, бяслаг зэрэг бүтээгдэхүүнд агуулагдах бөгөөд 1 граммд ногдох илчлэгийн хэмжээ 4 ккал байна.

Судалгааны ажлын зорилго, арга зүй

Энэ ажилд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн «Жишсэн дундаж нэг хүний хүнснээс авч буй бодит илчлэг шим тэжээл»-ийн статистик бодит тоон мэдээлэлд боловсруулалт хийж, шинжилгээ хийх боломжтой эсэхийг үнэлэх;
- Тоон мэдээлэлд шинжилгээ хийж, тоон болон чанарын үзүүлэлт хоорондын нөлөөллийг тодорхойлох;
- Тохирох регрессийн загвар бичих, тайлбар өгөх;
- Таамаглалын тусламжтайгаар монгол хүний хүнснээс авч буй бодит илчлэг, шим тэжээлийн төлөв байдлыг илэрхийлэх;
- Монгол хүний 1 хоногт хэрэглэж буй хүнсний шимт чанарын түвшинг үнэлэх, дүгнэх.

Энэ ажилд дараах арга зүйг хэрэглэхээр төлөвсөн болно. Үүнд:

- Статистик мэдээллийг бүлэглэх, программын код бичих;
- Математик статистикийн олон хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ хийх;
- Дисперсийн шинжилгээний үр дүнг шалгах;
- Регрессийн шинжилгээ хийх;
- Шим тэжээлийн нормын болон статистик мэдээллийн түүврүүд тодорхойлох (Хүнснээс авсан илчлэг, шим тэжээлийг улирлаар тодорхойлоход Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан нормыг ашиглана.);
- 2 түүврийн дундажийн ялгааг үнэлэх (Лапласын функц ашиглах).

I. ХҮНСНЭЭС АВАХ ШИМТ БОДИСЫН ШИНЖИЛГЭЭ

Дундаж нэг хүний хүнснээс авч буй бодит илчлэг шим тэжээлийг зуны болон сэрүүний улиралд, хот ба хөдөө гэсэн ангиллаар ялган хугацааны хувьд 2013-2020 оны тоон өгөгдлөөр бүлэглэлт хийсэн. Энэ нь дисперсийн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлнэ. Дисперсийн шинжилгээгээр илчлэгийн хувьд бодогдсон бүлэг бүрийн дундаж хэмжигдэхүүний утгыг Хүснэгт 1-д харуулав. Хугацааны нөлөөг 1-р хүчин зүйл, улирлыг 2-р хүчин зүйл, бүсчлэлийг 3-р хүчин зүйл гэж үзсэн тул тоон өгөгдлийн утга 3 индексээр илэрхийлэгдэнэ.

Хугацаа	Бүс	Улирал		Бүлгийн дундаж $(x_{-i**})(x_{-}i**)$	Бүлгийн дундаж $(x_{-**i})(x_{-}**i)$
		Зун	Сэрүүн		
2013	**хот**	x_{111}=2154.2x111=2154.2	x_{121}=2975.7 x121=2975.7	x_{-1**}=2445x-1**=2445	x_{-**1}=2607.88x-**1=2607.88
	хөдөө	x_{112}=2084.5x112=2084.5	x_{122}=2565.6 x122=2565.6		
2014	**хот**	x_{211}=2652.1x211=2652.1	x_{221}=3569.5 x221=3569.5	x_{-2**}=2985.98x-2**=2985.98	
	хөдөө	x_{212}=2637.5x212=2637.5	x_{222}=3084.8 x222=3084.8		
2015	**хот**	x_{311}=2544.1x311=2544.1	x_{321}=3552.4 x321=3552.4	x_{-3**}=2929.25x-3**=2929.25	
	хөдөө	x_{312}=2530.6x312=2530.6	x_{322}=3089.9 x322=3089.9		
2016	**хот**	x_{411}=2397.1x411=2397.1	x_{421}=3372.5 x421=3372.5	x_{-4**}=2795.4x-4**=2795.4	
	хөдөө	x_{412}=2399.1x412=2399.1	x_{422}=3012.9 x422=3012.9		
2017	**хот**	x_{511}=2777.5x511=2777.5	x_{521}=3684.3 x521=3684.3	x_{-5**}=3121.63x-5**=3121.63	x_{-**2}=3321.25x-**2=3321.25
	хөдөө	x_{512}=2746.4x512=2746.4	x_{522}=3278.3 x522=3278.3		
2018	**хот**	x_{611}=2836.8x611=2836.8	x_{621}=3515.4 x621=3515.4	x_{-6**}=3115.58x-6**=3115.58	
	хөдөө	x_{612}=2813.9x612=2813.9	x_{622}=3296.2 x622=3296.2		
2019	**хот**	x_{711}=x711=2707.8	x_{721}=3740.2 x721=3740.2	x_{-7**}=3127.13x-7**=3127.13	
	хөдөө	x_{712}=2717x712=2717	x_{722}=3343.5 x722=3343.5		
2020	**хот**	x_{811}=x811=2857.2	x_{821}=3629.6 x821=3629.6	x_{-8**}=3196.58x-8**=3196.58	
	хөдөө	x_{812}=2870.3x812=2870.3	x_{822}=3429.2 x822=3429.2		
Бүлгийн дундаж $(x_{-*i*})(x_{-}*i*)$		x_{-*1*}=3060.4x-*1*=3060.4	x_{-*2*}=2868.73x-*2*=2868.73		x_{-}=2964.57x-=2964.57

№	Үзүүлэлт	Чанарын үзүүлэлт	Бүлгийн дисперс ($S2i$)(Si2)	Үлдэгдэл дисперс ($\delta 2$)($\delta 2$)	Дитерминацийн коэ-т $Ri2=\delta 2Si2$Ri2=δ2Si2	Корреляцийн харьцаа $Ri=\delta 2Si2$ $\sqrt{}$Ri=δ2Si2	Вариацийн коэ-т $Vi=Six-i$Vi=Six-i
1	Илчлэг, ккал	Бүсчлэл	4071160	15355.1	0.0045	0.06	0.65
		Улирал	293895	15355.1	0.056	**0.23**	**0.19**
		Хугацаа	244569	15355.1	0.067	**0.25**	**0.17**
2	Уураг, гр	Бүсчлэл	20145.3	58.2	0.004	0.05	0.99
		Улирал	501.65	58.2	0.12	**0.34**	**0.17**
		Хугацаа	613.4	58.2	0.104	**0.31**	**0.19**
3	Тос, гр	Бүсчлэл	11533	35.5	0.004	0.06	1.19
		Улирал	462.8	35.5	0.079	**0.28**	**0.26**
		Хугацаа	377.56	35.5	0.088	**0.31**	**0.23**
4	Нүүрс ус, гр	Бүсчлэл	16128.1	247.5	0.016	0.12	0.30
		Улирал	4218.2	247.5	0.062	**0.24**	**0.15**
		Хугацаа	13272.9	247.5	0.019	0.14	0.27


Хүснэгт 1.


Хүснэгт 1-ээс харвал сүүлийн 8 жилийн тоон өгөгдлийн хугацааны хувьд 2013 оны дундаж илчлэг хамгийн бага буюу 2445 ккал, улирлын хувьд сэрүүний улирлын дундаж илчлэг хамгийн бага буюу 2868.73 ккал, бүсчлэлийн хувьд хотын дундаж илчлэг хамгийн бага буюу 2607.88 ккал байсан байна.


Хүснэгт 2. Гурван хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүн


Үндсэн шимт бодисын бусад үзүүлэлт болох уураг, тос, нүүрс ус зэрэг үзүүлэлтийн хувьд мөн бүлэглэлт хийж програмын үр дүнг гаргаж авсан. Програмын үр дүнг хавсралт хэсгийн програмын үр дүн 1-4-тэй дэлгэрэнгүй танилцаж болно. Дисперсийн шинжилгээний програмын гол үр дүнг түүж Хүснэгт 2-т нэгтгэж бичив. Хүснэгт 2-т тод хараар харуулсан тоо нь (корреляцийн харьцаа) нөлөөлөх хүчин зүйл болж байна гэсэн утгыг илэрхийсэн. Харин улаанаар тэмдэглэсэн тоо нь уг үзүүлэлт (бүсчлэл) нөлөөлөх үзүүлэлт биш утгыг илэрхийсэн.

Монгол хүний 1 хоногт хэрэглэж буй илчлэг, уураг, тос, нүүрс усны хэмжээнд улирал болон хугацаа гэсэн чанарын хүчин зүйлүүд нөлөөлж байгаа тул Хүснэгт 2-ын үр дүнг зургаар харуулбал дараах графикууд дүрслэгдэнэ.









Улирлын нөлөөллийг харуулахын тулд дараах графикыг байгуулж, загвар тодорхойлсон.





$$y=2.46+ 2.52x_1 + 10.24x_2 + 4.2x_3 \quad (1)$$

Монгол хүний сүүлийн 8 жилийн турш зуны улиралд хоол хүнснээс авсан шимт бодисын тоон үзүүлэлтээс дараах дүгнэлтийг хийж байна. Зуны улиралд уургийн хэмжээ 1 гр-аар нэмэгдэхэд илчлэг 2.52 ккал-оор, тосны хэмжээ 1 гр-аар нэмэгдэхэд илчлэг 10.24 ккал-оор, нүүрс усны хэмжээ 1 гр-аар нэмэгдэхэд илчлэг 4.2 ккал-оор нэмэгдэж байсан байна.

$$y=3.32»«+3.3x_1+9.9x_2+4.04x_3 \quad (2)$$

Харин сэрүүний улиралд уургийн хэмжээ 1 гр-аар нэмэгдэхэд илчлэг 3.3 ккал-оор, тосны хэмжээ 1 гр-аар нэмэгдэхэд илчлэг 9.9 ккал-оор, нүүрс усны хэмжээ 1 гр-аар нэмэгдэхэд илчлэг 4.04 ккал-оор нэмэгдэж байсан байна.

Хугацааны нөлөөллийг харуулахад «Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн А/12 дугаар тушаалын I хавсралтаар жишсэн нэг хүний хоногийн хүнснээс авах илчлэгийн хэрэгцээний нормийг Хүнс, хөдөө аж ахуйн болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 5 жил тутамд шинэчлэн батална» гэсэн заалт, тоон мэдээллийн хэт богино хугацааны өгөгдөл зэрэг нь хугацааны загвар бичихэд харшилж төвөгтэй асуудал тулгарсан. Гэвч Үндэсний статистикийн хорооноос гаргасан «Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачилал»-ын дараах тодорхойлолт судалгааны ажилд чухал үүрэг гүйцэтгэсэн. Үүнд: Бодитойгоор гарсан жишсэн нэг хүний хоногт хүнснээс авсан илчлэг, шим тэжээлийн хэмжээг, жишсэн нэг хүний хоногт хүнснээс авах ёстой илчлэг, шим тэжээлийн нормтой харьцуулахад 90 хувиас бага байвал хүнснээс авах илчлэг, шим тэжээлийн бодисуудыг хангалттай авч чадахгүй, 90-109 хувь байвал физиологийн нормийн түвшинд, 110 хувиас их байвал хэтрүүлсэн гэж үзнэ.

Мөн математик хувиргалтын тусламжтай шим тэжээлийн физиологийн нормийн түүвэр байгуулсан. Ингэснээр физиологийн нормийн түүвэр, бодит тоон өгөгдлөөр байгуулагдсан түүвэр хооронд жишилт хийх боломж бүрдсэн. Дээрх шалгуурыг баримтлан физиологийн нормын түвшинд тооцоо хийхэд $2500\cdot0.91\leq\mu\leq2500\cdot1.09$ гэдгээс $2275\leq\mu\leq2725$ тогтоогдов. Илчлэгийн

нормын дундаж түвшингийн хязгаарыг хялбар олж байгаа ч дисперс нь тодорхойгүй байгаа тул

$$\bar{x} - t \cdot \sigma_x \le \mu, \ \ \sigma_x = \sqrt{\frac{\sigma^2}{n}}$$

томъёог ашиглан σ^2 -ийг олж шимт чанарын үзүүлэлт тус бүрийн хувьд физиологийн нормын түвшинд тохирох дисперсийг тодорхойлов. Ингэснээр сүүлийн 8 жилийн илчлэгийн тоон өгөгдөл, тогтоосон стандартад нийцэж буй эсэхийг үнэлэх боломж бүрдэнэ. Жишээ болгож зуны улирлын илчлэгийн тооцоог дараах хүснэгтэд харуулъя.

Нийдэм	Түүврийн тоо	Түүврийн дундаж	Дисперс
физиологийн норм	$n_1 = 16$	$\bar{x}_1 = 2500$	$S_1^2 = 151910$
бодит тоон өгөгдөл	$n_2 = 16$	$\bar{x}_2 = 3060.4$	$S_2^2 = 227992$

Нэгдсэн дисперси $\delta^2 = \frac{16 \cdot 151910 + 16 \cdot 227992}{16+16-2} = 202614$, $\bar{x}_1 - \bar{x}_2 = \Delta x$, $\mu_1 - \mu_2 = \Delta\mu$ гэвэл стандарт алдаа $\delta_{\Delta x} = \sqrt{227992\left(\frac{1}{16} + \frac{1}{16}\right)} = 168.8$ болно. Бага түүвэр учраас $k = n_1 + n_2 - 2 = 24$, $\alpha = 0.05$, $t_{онол} = 2.16$ гэсэн Стьюдентийн тархалт ашиглана. Интервалын үнэлгээ нь $112.8 \le \Delta\mu \le 892.45$ болно. 95 хувийн магадлалтай үнэлэхэд 2 түүврийн дунджуудын зөрүү 112.8-аас 892.45 ккал интервалд байна. 2 нийдмийн хувьд ерөнхий нийдмийн дунджууд тэнцүү гэсэн дараах таамаглал дэвшүүлье.

$H_0: \mu_1 = \mu_2$ $\quad$ $H_1: \mu_1 \ne \mu_2$

$$t_{тооц} = \frac{3060.4 - 2500 - 0}{168.8} = 3.3$$

$H_0: -t_{онол} \le t_{тооц} \le +t_{онол}$ тул H_0 таамаглал няцаагдав. Эндээс дүгнэвэл 2 түүврийн илчлэгийн дундаж хэмжээ 95 хувийн магадлалтайгаар өөр байна. Өөрөөр хэлбэл, монгол хүний хоол хүнснээс авсан зуны улирлын илчлэгийн хэмжээ сүүлийн 8 жилийн хугацаанд физиологийн нормын стандартаас давсан байна. Монгол хүний 1 хоногт хоол хүнснээс авч буй хүнсний шимт бодисын үзүүлэлт тус бүрийн хувьд дэвшүүлсэн таамаглалын үр дүнг дараах хүснэгтээр харуулья.

Улирал	Шимт бодис	Стандарт хэмжээ		Түүврийн дундажуудын зөрүү	$t_{тооц}$	$\lvert t_{тооц} \rvert \le t_{онол}$
		дундаж	дисперс			
Зун	Илчлэг	*2500*	*151910*	[112.81; 892.45[	*3.3*	-
	Ууураг	*101*	*247.941*	[13.7; 58.26[	*3.49*	-
	Тос	69	115.719	[32.25; 50.15[	*9.9*	-
	Нүүрс ус	365	3238.11	[8.8; 111.36[	*2.53*	-
Сэрүүн	Илчлэг	*2500*	*151910*	[5.5; 651.7[	*2.2*	-
	Ууураг	106	273.097	[5.35;39.27[	*2.84*	-
	Тос	70	119.097	[-3.84;21.47[	*1.5*	+

Хүснэгт 3. Шимт бодисын тухай таамаглалын үр дүн

II. ДҮГНЭЛТ

• Монгол хүний 1 хоногт хоол хүнснээс авах шимт бодисын хувьд сэрүүний улирлын тос, нүүрс усны хэрэглээ физиологийн нормыг хангаж байна. Сэрүүний улирлын илчлэг, уурагын хэрэглээ физиологийн нормын хэмжээнээс давсан байна.

• Зуны улиралд монгол хүний 1 хоногт хоол хүнснээс авах шимт бодисын үзүүлэлтүүд бүгд физиологийн нормын хэмжээнээс давсан байна. Зуны улирлын тосны хэрэглээ анхаарал татахаар өндөр байсан байна. Монгол хүн илчлэг, уураг ихтэй хүнсийг аль ч улиралд илүү их хэрэглэдэг байна. Илчлэг, уургийн өндөр агууламжтай хүнсийг зохистой хэмжээгээр хэрэглэх хэрэгтэй.

• Хэрэв монгол хүний 1 хоногт хэрэглэж буй хүнсний хэрэглээний тоон мэдээлэл дэлгэрэнгүй өгөгдвөл энэ судалгаан дээр үндэслэн физиологийн нормоос илүү байгаа шимт бодисуудыг ямар бүтээгдэхүүнээс, хэдэн сард, ямар хэмжээгээр авч байгааг тодорхойлж гаргах бүрэн боломжтой юм.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ОНЦЛОГЫГ ДАРААХ БАЙДЛААР ДҮГНЭЖ БАЙНА. ҮҮНД:

• Энэ аргыг тодорхой стандарт болон журамтай, цөөн өгөгдөлтэй судалгаан дээр хэрэглэж болох юм гэсэн санааг өгч байна.

• Тоон өгөгдөл, стандарт 2-ыг харагдах байдал, эсхүл харьцаагаар нь шууд харж үнэлэхэд цаана нь байгаа чухал процесс хаягдахад хүрэх тул тохирох зөв аргыг олж хэрэглэх, эсхүл уг аргуудыг хослуулан хэрэглэх хэрэгтэй.

I. ХАВСРАЛТ

	DF	SumOfSq	MeanSq	FRatio	PValue
Хугацаа	7	1.71199×10^{6}	244569.	15.9276	2.81641×10^{-7}
Улирал	1	293895.	293895.	19.14	0.000241439
Бүсчлэл	1	4.07116×10^{6}	4.07116×10^{6}	265.135	9.31799×10^{-14}
Error	22	337811.	15355.1		
Total	31	6.41485×10^{6}			

***Програмын үр дүн 1**. Илчлэгийн нөлөөлөл*

	DF	SumOfSq	MeanSq	FRatio	PValue
Хугацаа	7	4293.78	613.397	10.5456	9.02055×10^{-6}
Улирал	1	501.653	501.653	8.6245	0.00763239
Бүсчлэл	1	20145.3	20145.3	346.341	5.96933×10^{-15}
Error	22	1279.65	58.166		
Total	31	26220.3			

***Програмын үр дүн 2**. Уургийн нөлөөлөл*

	DF	SumOfSq	MeanSq	FRatio	PValue
Хугацаа	7	2642.89	377.556	10.6212	8.52151×10^{-6}
Улирал	1	462.84	462.84	13.0203	0.00155969
Бүсчлэл	1	11533.	11533.	324.44	1.17373×10^{-14}
Error	22	782.044	35.5475		
Total	31	15420.8			

***Програмын үр дүн 3.** Тосны нөлөөлөл*

	DF	SumOfSq	MeanSq	FRatio	PValue
Хугацаа	7	92910.5	13272.9	53.6313	2.28624×10^{-12}
Улирал	1	4218.21	4218.21	17.0443	0.000440854
Бүсчлэл	1	16128.1	16128.1	65.168	5.07872×10^{-8}
Error	22	5444.66	247.485		
Total	31	118701.			

Програмын үр дүн 4. *Нүүрс усны нөлөөлөл*

	Estimate	Standard Error	t-Statistic	P-Value
1	2.46051	6.61393	0.372019	0.728749
x_1	2.52222	0.277964	9.07388	0.000817724
x_2	10.2351	0.100472	101.87	5.56783×10^{-8}
x_3	4.21846	0.055677	75.7667	1.81859×10^{-7}

,

	DF	SS	MS	F-Statistic	P-Value
x_1	1	301966.	301966.	730556.	1.12419×10^{-11}
x_2	1	5222.79	5222.79	12635.7	3.756×10^{-8}
x_3	1	2372.8	2372.8	5740.59	1.81859×10^{-7}
Error	4	1.65335	0.413337		
Total	7	309563.			

, $AdR^2 = 0.9$

Програмын үр дүн 5. *Загвар 1-ийн статистик шинжүүрийн утга*

	Estimate	Standard Error	t-Statistic	P-Value
1	3.32253	2.68535	1.23728	0.283653
x_1	3.32928	0.258147	12.8969	0.000208452
x_2	9.8714	0.128232	76.9809	1.70659×10^{-7}
x_3	4.04411	0.0560119	72.2009	2.20509×10^{-7}

,


	DF	SS	MS	F-Statistic	P-Value
x_1	1	424975.	424975.	1.93677×10^{6}	1.59953×10^{-12}
x_2	1	313.026	313.026	1426.58	2.93448×10^{-6}
x_3	1	1143.85	1143.85	5212.97	2.20509×10^{-7}
Error	4	0.877697	0.219424		
Total	7	426433.			

, $AdR^2 = 0.9$

Програмын үр дүн 6. *Загвар 2-ийн статистик шинжүүрийн утга*

АШИГЛАСАН НОМ, ПРОГРАМЫН ЖАГСААЛТ:

- «Mathematica 12.1» програм
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 1212.mn
- Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачилал. УБ., 2015.
- Цэвээннамжил.Ц. Математик статистик. УБ., 2017.





СИТИ ХӨДӨЛМӨРИЙН БИРЖ

Ажлын зар нэмэх | Зарлагдсан ажлын байр

400+
ЖИЛД ДУНДЖААР

6 000+
НИЙТ ТӨГСӨГЧИД

“СИТИ” хөдөлмөрийн бирж ажиллаж эхэллээ

Манай “СИТИ” Их сургууль оюутан, төгсөгчдөө ажилд ороход, өөрийн бизнесээ эхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажил горилогчдод тавигддаг, шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхөд нь туслах зорилгоор “CitiZone” инновац, бизнес хөгжлийн төв байгуулсан билээ.

Тэгвэл энэхүү ажлын хүрээнд “СИТИ” хөдөлмөрийн бирж шинээр байгуулж,оюутан,төгсөгчид болон ажил олгогчдыг холбох гүүр бий болголоо.

Ажил олгогч Та бүхэн www.citi.edu.mn цахим хуудасны “Төгсөгч” цэсний “СИТИ хөдөлмөрийн бирж”-д хандаж, хайж байгаа ажилтан, хүний нөөцөд тавигдах шаардлага, мэргэжлийн чиглэл, ур чадварын талаар бичихэд хангалттай юм. Бид 1700 гаруй оюутан болон 6000 гаруй төгсөгчдөөсөө сонгон шалгаруулж, таны хайж буй ажлын байранд тохирох ажилтныг зуучилж өгөх боломжтой.

*Та бүхэн **www.citi.edu.mn/alumni** болон **www.citi.edu.mn/citizone1** линкээр орж,дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.*

Баярлалаа.

Х.АРИУНАА
Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

О.ОЮУНДАЛАЙ
«СИТИ» Их сургуулийн Барилга, архитектур, дизайны сургуулийн Компьютер, график дизайны тэнхимийн багш

ӨӨРТӨӨ ҮЙЛЧЛЭХ ТЕХНОЛОГИ (SST)-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ НЬ

Хураангуй

Технологийн хурдацтай хөгжил болон харилцагчийн зан төлөвийн өөрчлөлтөөс шалтгаалан сүүлийн жилүүдэд бизнесийн бүх төрлийн үйлчилгээг хэрэглэгчид дижитал сувгаар дамжуулан авах хандлага улам бүр нэмэгдсээр байна. Үүний нэг тод жишээ нь банк санхүү, даатгал, үүрэн холбоо, үзвэр, үйлчилгээ зэрэг Монголын томоохон бизнесийн салбарууд өөрөө өөртөө үйлчлэх технологи (Self-service Technology)-ийг (цаашид «SST» гэх) нэвтрүүлэн хэрэглэгчдэдээ бүтээгдэхүүн, үйлчилгээгээ амжилттай хүргэж байна. Тиймээс бид энэхүү судалгааны ажлаараа SST-ийн үйлчилгээний чанарт ямар хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлж буйг, цаашлаад SST-ийн үйлчилгээний чанар хэрэглэгчдийн сэтгэл ханамжид хэрхэн нөлөөлдгийг судлахыг зорилоо. Энэхүү судалгааны ажлаараа Монголын томоохон үүрэн холбооны компаниудын нэг «UNITEL» ХХК-ийн дижитал сувгуудаар тогтмол үйлчилгээ авдаг 151 хэрэглэгчээс онлайнаар судалгаа авч, судалгааны өгөгдлийг цуглуулан олон хувьсагчийн регрессийн загвар болон нэг хувьсагчаас хамаарсан шугаман регрессийн загвараар судалгааны таамаглалуудыг баталсан.

Түлхүүр үгс

SS, өөртөө үйлчлэх технологи, хэрэглэгчийн сэтгэл ханамж, хэрэглэгчийн үнэнч байдал, зан үйлийн зорилго

Оршил

Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХТ)-ийн хөгжил нь үйлчилгээний компаниуд болон хэрэглэгч хоорондын харилцааны хэлбэрийг өөрчилж, улмаар үйлчилгээний стандартууд сайжирсан. (Barrett, Davidson, Prabhu, & Vargo, 2015; Lovelock & Gummesson, 2004)

Сүүлийн арван жилийн хугацаанд SST-ийг нэвтрүүлэх нь үйлчилгээний салбарын бизнесийн хэлбэрийг шинээр гаргаж ирсэн. (Leung & Matanda, 2013; Verhoef нар, 2009) SST нь үйлчилгээ худалдан авагч ба ханган нийлүүлэгч байгууллагын шууд холбоог сольсон (Meuter, Ostrom, Roundtree, & Bitner, 2000)

Энэ нь хэрэглэгч үйлчилгээний байгууллагын ажилтнуудтай шууд харьцахгүйгээр үйлчилгээг бий болгох, ашиглах боломжийг олгодог. (Eastlick, Ratto, Lotz, & Mishra, 2012; Ju Rebecca Yen & Gwinner, 2003; Martins, Oliveira, & Popovič, 2014)

Үйлчилгээний компаниудаас үйлчилгээ авахын тулд хэрэглэгчийн хувьд ажилчдын үзүүлж буй үйлчилгээнээс эхлээд хэрэглэгчийн өөрөө өөртөө үйлчилдэг үйлчилгээ хүртэл байдаг. (Hilton, Hughes, Little, & Marandi, 2013; Turner & Shockley, 2014)

Үйлчилгээний компаниудын үйлчилгээний процесс бүтээмж, ур чадвар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор SST-ийг эхлүүлсэн. (Curran & Meuter, 2005; Kelly, Lawlor, & Mulvey, 2017; Kokkinou & Cranage, 2013; Walker, Craig-Lees, Hecker, & Francis, 2002 ; Zeithaml & Gilly, 1987)

Үүнээс гадна орчин үеийн, хурдан шуурхай дижитал сувгуудаар дамжуулан хэрэглэгч үйлчилгээ авах боломжийг санал болгохыг зорьж байна. (McGrath & Astell, 2017; Meuter, Ostrom, Bitner, & Roundtree, 2003; Reinders, Dabholkar, & Frambach, 2008)

Ингэснээр хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээг хангахаас гадна тэдний сэтгэл ханамжийг илүү сайжруулах боломжтой байдаг. (Bitner, Ostrom, & Meuter, 2002; Ganguli & Roy, 2011; Johnson, Bardhi, & Dunn, 2008). Unitel app, chatbot, KIOSK, www.unitel.mn гэх мэт зарим SST нь хэрэглэгчдийн дунд түгээмэл байдаг.

SST-ийг «Үйлчилгээний байгууллагын ажилчдын шууд оролцоогүйгээр хэрэглэгчдэд үйлчилгээ авах боломжийг олгодог технологийн интерфейс» гэж тодорхойлсон байдаг. (Meuter et al. 2000)

Цаашилбал, SST нь бизнес эрхлэгчдэд илүү ашигтай байж болох бөгөөд ингэснээр ажилтнуудаа SST-ээр орлуулж болох ба зардлыг бууруулж, цөөн тооны эх үүсвэрээр хэрэглэгчиддээ үйлчлэхэд нь туслах болно. (Curran & Meuter, 2005; Yang & Klassen, 2008) SST нь бизнес эрхлэгчдэд сургалт, тоног төхөөрөмж, харилцаа холбооны зардлыг бууруулахад нь тусалдаг. (Leung & Matanda, 2013)

SST үйлчилгээ нь ажилчдын оюун санааны хэлбэлзэлд өртөхгүй илүү тогтвортой үйлчилгээг санал болгодог. (Liljander, Gillberg, Gummerus, & van Riel, 2006; Weijters, Rangarajan, Falk, & Schillewaert, 2007)

I. ОНОЛЫН ТОЙМ СУДАЛГАА

A. SST ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

Үйлчилгээний чанарын үзэл баримтлал нь үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой журам (Parasuraman et al., 1985) болон үйлчилгээний үр дүн (Lehtinen & Lehtinen, 1991)-г гаргасан байна. Үйлчилгээний чанарын хэмжээс ба түүний хэмжилттэй холбоотой ойлголт нь сүүлийн хэдэн арван жилд гарч ирсэн. (Jain & Gupta, 2004; Lehtinen & Lehtinen, 1991)

Үйлчилгээний чанарын парадигмыг шалгах зорилгоор хэд хэдэн судалгааг хийсэн (Cronin, Brady, & Hult, 2000; Cronin & Taylor, 1992; Parasuraman et al., 1985) (Parasuraman et al. 1988) нь үйлчилгээний чанар, түүний үзэл баримтлал, бүтцийн хувьд таван хэмжээс болгон боловсруулсан. Эдгээр хэмжигдэхүүнүүд нь i) найдвартай байдал, ii) хариуцлага, iii) баталгаатай байдал, iv) бусдын асуудлыг ойлгох, v) мэдрэмжтэй байдлыг багтаадаг.

Түүнчлэн үйлчилгээний чанарыг тодорхойлохын тулд үйлчилгээний үйл явцын орчны талаар «SERVQUAL» хэмжүүрийг нэвтрүүлсэн. Үйлчилгээний чанарын гурван хэмжээст загвар нь «i) техникийн чанар, ii) үйл ажиллагааны чанар, iii) байгууллагын имиж» гэж Грёнроос (1984) гаргаж ирсэн. Үүнтэй адил өөр нэг загварыг Лехтинен (1991) гурван хэмжээсээр санал болгосон i) физик чанар, ii) интерактив чанар, iii) байгууллагын чанар. Тэдний үзэж байгаагаар бие махбодын чанар нь үйлчилгээ үзүүлэх хугацаандаа үйлчилгээний үйлдвэрлэлийн процесст орсон биет бүтээгдэхүүн, мөн үйлчилгээний хэрэглээтэй холбоотой юм.

Технологийг хүлээн авах загвар (TAM)-ыг хэрэглэгчийн технологийг нэвтрүүлэх зан төлөвийг урьдчилан харах зорилгоор Дэвис (1989) боловсруулсан. TAM-ийн дагуу технологийг хүлээн зөвшөөрөх нь технологийн үйлчилгээний хандлага, хүсэл эрмэлзлийн цар хүрээгээр илэрхийлэгддэг бөгөөд үүнийг ашиглахад хялбар (PEOU), ашиг тустай гэж үздэг (PU) (Дэвис, 1989; Дэвис, Багоззи, & Варшоу, 1989) (Lin, Shih, and Sher (2007) нь технологийг үйлчилгээнд бэлэн болгох (TR) ба TAM-ийг TRAM загварт нэгтгэн цахим үйлчилгээг ашиглаж байхдаа хэрэглэгчдийн хүсэл эрмэлзлийг илүү нэмэгдүүлдэг. Венкатеш, Моррис, Дэвис

(2003) нар технологийн системийг ашиглах зан төлөвийн талаарх хэрэглэгчийн санаа бодлыг тайлбарлахын тулд Технологийг хүлээн авах, ашиглах нэгдсэн онолыг (UTAUT) урьдчилан таамаглаж байсан. UTAUT нь хүмүүс технологийн системийн хэрэглээнд оролцож, зан төлөвийг төлөвшүүлдэг бөгөөд үүнд i) гүйцэтгэлийн хувьд, ii) хүчин чармайлт, iii) нийгмийн нөлөөлөл, iv) нөхцөлийг хөнгөвчлөх гэсэн дөрвөн үндсэн бүтцээр удирддаг.

Үйлчилгээний чанарын бүтцийг хэмжих хэд хэдэн хэмжүүр байдаг. Гэсэн хэдий ч SERVQUAL (Parasuraman et al., 1988), SERVPREF (Cronin & Taylor, 1992) зэрэг нь үндсэндээ үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгч (ажилтан) хоорондын харилцан үйлчлэлийг судлахад зориулагдсан боловч харилцан үйлчлэлийг хэрэглэгчийн технологийн интерфейс (интерактив төхөөрөмж) хамаарна. Барнс, Видген (2001) нар хэмжлийн шинэ хувилбарыг гаргажээ.

Дижитал үйлчилгээг үзүүлж байгаа байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлэх зорилгоор E-S-QUAL-ийг бий болгосон. (Парасураман, Зейтхамл, Малхотра; 2005)

SSTQUAL-ийн баталгаажуулалт нь байгууллагын болон хэрэглэгчийн зан төлөвийн олон янзын масштабын хуулбарыг янз бүрийн нөхцөлд найдвартай, хүчин төгөлдөр байдлын туршилтаар баталсан байна. (Considine & Cormican, 2016; Demirci Orel & Kara, 2014; Kumar & Mittal, 2015; Радомир ба Нистор, 2012, 2014)

SSTQUAL (Lin & Hsieh, 2011) нь функционал хамаарал, хэрэглээ, аюулгүй байдал, дизайн, баталгаа, ашиг сонирхол, тохируулга гэсэн 20 зүйл, долоон хэмжигдэхүүнээс бүрдэнэ.

• Функционал байдал нь «найдвартай байдал, ашиглахад хялбар, хариу үйлдэл үзүүлэх» зэрэг SST-ийн шинж чанаруудыг бий болгодог.
• Хэрэглээ гэдэг нь хэрэглэгчийн системийг ашиглах талаарх санал бодлыг хэлнэ.
• Аюулгүй байдал/нууцлал нь хэрэглэгчдийн хувийн асуудалтай холбоотой байдаг.
• Дизайн нь системийн ерөнхий зохион байгуулалтай холбоотой.
• Баталгаажуулалт нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой чадвар, нэр хүндийг харуулдаг.
• Ашиг сонирхол нь үйлчлүүлэгч байгууллага санал болгож буй үйлчилгээтэй холбоотой юм.
• Өөрчлөлтийг хэрэглэгчдийн хэрэгцээтэй танилцах, хэрэглэгчдийн хамтарсан үйлдвэрлэлээр дамжуулан эдгээр үйлчилгээг бий болгох чадвар гэж тодорхойлдог.

Б. SST ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР БА ҮНЭНЧ БАЙДАЛ

Ли, Ли, Фейк нар (2001) хэрэглэгчдийн үнэнч байдлыг «ам дамжсан үгс, худалдан авах магадлал нэмэгдэх, байгууллагын бүтээгдэхүүнийг байнга худалдаж авахтай холбоотой» гэж тодорхойлсон. Пирсон (1994) хэрэглэгчдийн үнэнч байдлыг «компанийн талаар таатай хандлагатай, компанийн бүтээгдэхүүн-үйлчилгээг байнга худалдан авч, бүтээгдэхүүн-үйлчилгээг бусдад дамжуулах хэрэглэгчдийн сэтгэлгээ» гэж тодорхойлсон.

Зан төлөвийн онол (TPB) нь үйл ажиллагааны онолын үргэлжлэл юм. (Ajzen, 1985, 1991; Ajzen & Fishbein, 1975)
Зан төлөв нь хандлага, субьектив хэм хэмжээ, зан төлөвийг хянах чадварын үр дүн юм. TPB нь хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдал, SST үйлчилгээний чанарт хандах хандлагыг судлах зорилгын суурь болж байна. Үүнтэй адил ашгийг (Heskett, Sasser, & Schlesinger, 1997; Heskett & Schlesinger, 1994) нь компаниудад өсөлт, ашиг хүртэхийн тулд сэтгэл ханамжтай, үнэнч хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх нь чухал болохыг харуулж байна. Тиймээс судалгааны эхний таамаглалыг дараах байдлаар харуулж байна.

H1: SST үйлчилгээний чанар нь хэрэглэгчийн үнэнч байдалтай эерэг, чухал харилцаатай байдаг.

В. SST ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР БА ЗАН ТӨЛӨВ

Хэрэглэгчийн зан төлөвийн тухайд зан төлөвийн зорилго ба бодит зан төлөвийн хоорондын уялдаа холбоог ойлгохын зэрэгцээ үйл ажиллагааны онолыг

(Fishbein & Ajzen, 1975) гаргасан байна. Зан төлөвийг харуулсан TRA-ийн эерэг шинж чанарууд нь тухайн хүний хүсэл зоригийн үр дүн юм. (Fishbein & Ajzen, 1975)

Оновчтой үйл ажиллагааны онолоос (Fishbein & Ajzen, 1975) үндэслэсэн төлөвлөсөн зан төлөвийн онол (Ajzen, 1991) нь шинэ технологийн хэрэглээнд хэрэглэгчийн хандлага нь зорилгод нөлөөлдөг гэж үздэг. (Ajzen, 1991; Curran & Meuter, 2005; Fishbein & Ajzen, 1975)

Хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа нь зан төлөв, хүсэл эрмэлзлийн хоорондын холбоог сайн тогтоожээ. (De Canniire, De Pelsmacker, & Geuens, 2009; Webb & Sheeran, 2006) Технологийг нэвтрүүлэх тухай бодит зан төлөв нь технологийн системийн хэрэглээний давтамж, эсхүл түвшний хувьд ерөнхийд нь тодорхойлдог болохыг харуулж байна. (Demoulin & Djelassi, 2016; Venkatesh & Bala, 2008; Venkatesh & Davis, 2000; Venkatesh, Thong, & Xu, 2012)

Демоулин, Джеласси нар (2016) хэрэглэгчдэд хувь хүн, систем, нөхцөл байдлын хүчин зүйлийг харгалзан үзсэн SST-ийг ашиглах зорилго, бодит хэрэглээг судлав. Тэдний олж мэдсэн үр дүнгүүд нь өнгөрсөн үеийн ашиглалтыг нөхцөл байдалд харуулсан хүчин зүйлүүд, зан төлөв нь SST-т хандах зан төлөвийн чухал элемент гэж үзжээ. Дээрх хэлэлцүүлгийн үндсэн дээр хоёр дахь таамаглалыг доор бичсэн байна.

H2: SST-ийн үйлчилгээний чанар нь зан төлөвтэй эерэг, чухал харилцаатай байдаг.

Г. SST ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР БА ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Сэтгэл ханамж нь хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэхэд эерэг сэтгэгдэл төрүүлж буй байдал гэж үздэг. (Lin & Hsieh, 2006) Хэрэглэгчийн зорилгыг биелүүлэх хүлээгдэж буй бүтээгдэхүүн, хэрэглэгчийн брэндээс олж авсан ашгийг харьцуулж үзэхэд сэтгэл ханамж хангалттай гэж үздэг. (Bergman & Klefsjц, 2010; Cronin et al., 2000; Loudon & Делла Битта, 1993)

Оливер (1997)-ийн үзлийн дагуу сэтгэл ханамжийг «хэрэглэгчийн тааламжтай хариу үйлдэл» гэж үздэг. Энэ нь үндсэндээ хэрэглээтэй холбоотой таатай туршлагыг бий болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанарын талаарх үнэлгээ юм.

Эрдэмтэд SST-ийн хэрэглэгчдийн сэтгэл ханамж, үнэнч байдал, зан төлөвийн талаар хэрэглэгч эерэг сэтгэгдэлтэй байгааг судалсан. (Demirci Orel & Kara, 2014; Lin & Hsieh, 2007; Zhao, Mattila, & Eva Tao, 2008) Demirci Orel and Kara (2014) SSTQUAL-ийг ажиллуулснаар өөртэй үйлчлэх үйлчилгээний чанар нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн шууд бус нөлөөгөөр үнэнч байдалд эерэг нөлөө үзүүлдэг болохыг судалсан.

Икбал, Хассан, Шариф, Хабиба нар (2017) нь үйлчилгээний чанар, байгууллагын имиж, хэрэглэгчдийн үнэнч байдал зэрэг нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжтай холбоотойг олж тогтоожээ. Тиймээс дараах таамаглалуудыг дэвшүүлсэн болно.

H3: SST үйлчилгээний чанар нь хэрэглэгчийн сэтгэл ханамжтай эерэг, чухал харилцаатай байдаг.

H4: Хэрэглэгчийн сэтгэл ханамж нь SST үйлчилгээний чанар ба зан төлөв хоорондоо хамааралтай.


H5: Хэрэглэгчийн сэтгэл ханамж нь SST үйлчилгээний чанар ба хэрэглэгчийн үнэнч байдлын хоорондын харилцааг зохицуулдаг.

H6: Хэрэглэгчдийн сэтгэл ханамж нь зан төлөвтэй эерэг бөгөөд чухал харилцаатай байдаг

H7: Хэрэглэгчийн сэтгэл ханамж нь хэрэглэгчийн үнэнч байдалтай эерэг бөгөөд чухал харилцаатай байдаг.

Касири, Гуан Ченг, Самбасиван, Сидин нар (2017) үйлчилгээний чанарын техникийн болон үйл ажиллагааны чанарын элементүүдээр хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэнч байдалд үзүүлэх эерэг нөлөөлөлд дүн шинжилгээ хийсэн.

Тиймээс тэд өөрсдийн хийсэн дүн шинжилгээнд үндэслэн дараах таамаглалыг боловсруулсан. (Зураг 1)



Зураг 1 Судалгааны загвар

II. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгаанд оролцсон хэрэглэгчдээс 7 дэд хэмжүүр бүхий 20 шалгуурын ач холбогдлыг үнэлүүлсэн. Тухайн шалгуур үзүүлэлтийг энгийн өгүүлбэрээр томьёолон асууж, likert-ийн 5 хэмжүүр (1 = огт санал нийлэхгүй – 5 = бүрэн санал нийлнэ) үнэлүүлсэн. Судалгаанд Unitel XXK-ийн веб сайтаар тогтмол бүтээгдэхүүн үйлчилгээ авдаг 151 хэрэглэгч оролцсон бөгөөд демографикийн шинжилгээг Хүснэгт 1-т харуулав. Мөн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн дижитал сувгийн хэрэглээ болон бүтээгдэхүүн хэрэглээний шинжилгээг Хүснэгт 2-т харуулав. Хүчин зүйлийн шинжилгээний хүлээн зөвшөөрөгдсөн түүврийн хэмжээг хангаж буйг хэлэх нь зүйтэй. (20*5=100 хамгийн бага түүврийн хэмжээ).

Хүйс	Давтамж	Хувь
Эрэгтэй	60	39.7%
Эмэгтэй	91	60.3%
Нийт	**151**	**100.0%**
Нас		
18 нас хүртэл	4	2.6%
19-25 нас	47	31.1%
26-35 нас	82	54.3%
36-45 нас	11	7.3%
46-55 нас	6	4.3%
55 наснаас дээш	1	0.7%
Нийт	**151**	**100.0%**
Боловсролын түвшин		
Бүрэн дунд боловсрол	16	10.6%
Дипломын сургалт	6	4.0%
Бакалавр	97	64.2%
Магистр ба түүнээс дээш	32	21.2%
Нийт	**151**	**100.0%**
Ажил эрхлэлтийн байдал		
Тэтгэвэрт, Ажилгүй	17	11.3%
Оюутан	14	9.3%
Оюутан, ажил хийдэг	13	8.6%
Цагийн ажил хийдэг	6	4.0%
Ажил эрхэлдэг	101	66.9%
Нийт	**151**	**100.0%**
Сарын өрхийн орлого		
500'000 - аас бага	16	10.6
0,5-1,5 сая	78	51.7
1,5-3 сая	40	26.5
3-5 сая	8	5.3
5 саяаас дээш	9	6.0
Нийт	**151**	**100.0%**

2.1. Загварын тогтвортой байдлын хэмжүүрүүд

Загварын тогтвортой байдлыг хэмжих сайн үзүүлэлт бол Кронбахын альфа юм. 0.7-ээс дээш утга нь шалгаж буй бүтэц нь нийцтэй болохыг харуулж байна. Загварын тогтвортой байдлыг хэмжих өөр нэг хүчин төгөлдөр үзүүлэлт бол хүчин зүйлүүдийн ачаалал/ loading гэж нэрлэгддэг утга нь 0.7-аас их утгыг авах ёстой бөгөөд бүрэлдэхүүн хэсгийн найдвартай байдал (CR) ба ялгаж авсан дундаж дисперсийн индекс (AVE) тус тус 0.7 ба 50%-иас их байх ёстой. Хүснэгт 9-д санал болгож буй найдвартай байдлын хэмжүүрийг хүчин зүйл бүрийн ачаалал/Loading-ын хамт үзүүлэв.

2.2. Олон хувьсагчийн регрессийн шинжилгээ

Функциональ байдал, тааламжтай байдал, аюулгүй байдал, загварлаг байдал, баталгаатай байдал, хялбар байдал,

надад зориулж тохируулагдсан байдал зэрэг үзүүлэлтүүдийг SST технологийн үйлчилгээний чанарт хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох зорилгоор олон хувьсагчийн регрессийн загвараар үнэлгээ хийсэн. Эдгээр 7 фактор маань Хүснэгт 3-т харуулснаар SST үйлчилгээний чанарт R2 = 1.000 буюу SST технологийн үйлчилгээний чанарыг 100% тайлбарлаж чадаж байна. Хүснэгт 7 нь бүх факторын хувьд SST үйлчилгээний чанарт 14.3%-иар жигд эерэг нөлөөлж буйг илтгэж байна. Мөн SST үйлчилгээний чанарыг хэрэглэгчийн сэтгэл ханамжид хэрхэн нөлөөлж буйг нэг хувьсагчаас хамаарсан шугаман регрессийн загвар үнэлсэн ба моделийн үр дүнг Хүснэгт 4-т харууллаа. Үүнд R2 = .835 буюу SST үйлчилгээний чанар нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийн 83.5%-ийг тайлбарлаж чадаж байна. SST үйлчилгээний чанарын хэрэглэгчийн сэтгэл ханамжид нөлөөлөх нөлөөллийн хүлээн зөвшөөрөх байдлыг ANOVA буюу дисперсийн шинжилгээгээр sign=.000 учир хүлээн зөвшөөрөгдөж буйг Хүснэгт 5-аар харууллаа. SST технологийн үйлчилгээний чанар 1 нэгж хувиар буурах/өсөхөд дагаад хэрэглэгчийн сэтгэл ханамж 85.2% буурах/өсөх хандлагатай байдгийг судалгааны үр дүн харуулж байна Хүснэгт 4-т загварын коэффициентын үр дүнг харуулав.

ХҮСНЭГТ 2. MODEL SUMMARY OF SST SERVICE QUALITY

Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate
1	1.000[a]	1.000	1.000	.00000

a. Predictors: (Constant), WCUS, WFUN, ASU, WCON, WDES, WSEC, WENJ

Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate
1	.914[a]	.835	.834	.36917

a. Predictors: (Constant), Satisfact

ХҮСНЭГТ 4. ANOVA OF SST SERVICE QUALITY

a) Dependent Variable: WebSSTServQuality
b) Predictors: (Constant), WCUS, WFUN, ASU, WCON, WDES, WSEC, WENJ

Model		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
1	Regression	120.853	7	17.265		.
	Residual	.000	140	.000		
	Total	120.853	147			

ХҮСНЭГТ 5. ANOVA OF CUSTOMER SATICATION

Model		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
	Regression	100.955	1	100.955	740.747	.000[b]
	Residual	19.898	146	.136		
	Total	120.853	147			

a) Dependent Variable: WebSSTServQuality
b) Predictors: (Constant), Satisfact

ХҮСНЭГТ 6. COEFFICIENTS OF SST SERVICE QUALITY

Model		Unstandardized coefficients		Standardized Coefficients	T	Sig.
		B	I. Std. Error	Beta		
1	(Constant)	3.842E-15	.000		,000	1.000
	WFUN	,143	.000	,159	78202355.66	0.000
	WENJ	,143	.000	,151	52332629.04	0.000
	WSEC	,143	.000	,158	63806604.90	0.000
	WDES	,143	.000	,160	62369292.31	0.000
	ASU	,143	.000	,164	82583787.40	0.000
	WCON	,143	.000	,151	51023110.74	0.000
	WCUS	.143	.000	163	77033428.54	0.000

ХҮСНЭГТ 7. COEFFICIENTS OF CUSTOMER SATISACTION

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	.619	.119		5.198	.000
	Satisfact	.852	.031	.914	27.217	.000

ХҮСНЭГТ 8. Дэд хэмжүүр бүрийн хувьд тооцоолсон найдвартай байдлын хэмжүүрүүд, нийт найдвартай байдлын (CR), average variance extracted (AVE) болон cronbach's alpha

CONSTRUCTS	Үйлчилгээний чанарын хэмжүүр	LOADING (Λ)	CRONBACH'S A	CR	AVE
FUNCTIONAL			0.905	0.93	73%
FUN-1W.	Би UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар үйлчилгээг төвөггүй авч чаддаг.	.886			
FUN-2.W.	UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар үйлчилгээг авах үйл явц тодорхой байдаг.	.885			
FUN3 .W.	Би богино хугацаанд UNITEL-ийн дижитал суваг : WWW.UNITEL.MN веб сайтаар аар хүссэн үйлчилгээ авч чаддаг.	.875			
FUN-4.W.	UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар үйлчилгээг авахад бага хүчин чармайлт шаарддаг.	.810			
FUN-5.W.	UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар функц/үйл ажиллагаа бүр нь алдаагүй байдаг.	.803			
ENJOYMENT			0.883	0.92	7496
ENJ-1.W.	UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар үйл ажиллагаа сонирхолтой байдаг.	.883			
ENJ-2.W.	UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар ашиглах боломжтой болсондоо баяртай байна.	.869			
ENJ-3.W.	UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар нь сонирхолтой нэмэлт функцуудтай байдаг.	.856			
ENJ-4.W.	UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар нь надтай холбогдох бүх мэдээллийг өгдөг.	.835			
SECURITY			0.852	0.87	77%
SEC-1.W.	UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар -ийг ашиглан хийсэн гүйлгээндээ аюулгүй гэдгээ мэдэрдэг.	.883			
SEC-2.W.	Намайг UNITEL-ийн дижитал суваг: WWW.UNITEL.MN веб сайтаар -ийг ашиглах үед нууцлалын талаар тодорхой бодлогыг зааж өгдөг.	.869			
DESIGN			0.853	0.87	77%

DES-2.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР НЬ ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАДАГ.	.909			
DES-1.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР -ИЙН ЦЭСНҮҮД НЬ ХАРАГДАХ БАЙДАЛ САЙТАЙ.	.859			
ASURRANCE			0.853	0.81	78%
ASU-1.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР -ААР ҮЗҮҮЛЖ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭ ОЛОНД САЙН ҮНЭЛЭГДСЭН БАЙДАГ.	.898			
CONVENIENCE			0.910	0.94	85%
CON-3.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР -ИЙГ АШИГЛАХАД ХЯЛБАР БӨГӨӨД ТОХИРОМЖТОЙ.	.944			
CUS-1.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР -Т ХҮРЭХЭД ТУХТАЙ БӨГӨӨД ХЯЛБАР БАЙДАГ.	.937			
CON-1.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР -ИЙГ ХЭРЭГЛЭГЧИД ТОХИРОМЖТОЙ АЖЛЫН ЦАГ(24/7)-ТАЙ БАЙДАГ.	.915			
CUSTOMIZATION			0.931	0.96	88%
CUS-2.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР НЬ МИНИЙ АШИГ СОНИРХОЛД МАШ САЙН НИЙЦСЭН БАЙДАГ.				
CUS-1.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР НЬ МИНИЙ ОНЦГОЙ ХЭРЭГЦЭЭГ ОЙЛГОДОГ.				
CUS-3.W.	UNITEL-ИЙН ДИЖИТАЛ СУВАГ: WWW.UNITEL.MN ВЕБ САЙТААР НЬ ЗӨВХӨН НАДАД ЗОРИУЛЖ БОЛОХУЙЦ ТОХИРУУЛАГДСАН ОНЦЛОГТОЙ БАЙДАГ.				

---oOo---

ДҮГНЭЛТ

Дэлхий нийтээр COVID 19-тэй холбоотойгоор мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХТ)-ийн салбар эрчимтэй хөгжиж байна. Монгол Улсын хувьд SST үйлчилгээг хэрэглэгч илүү хэрэглэх хүсэлтэй болж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд технологи дээр суурилсан үйлчилгээнүүд гаргаж байгаа бөгөөд хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэнч хэрэглэгч бий болгох технологи ашиглаж, үйлчилгээ авах зан төлөвийг хэрэглэгчдэд суулгах тал дээр ажиллаж байна.

Энэхүү судалгаанд «Өөртэй үйлчлэх технологи »SST (self service technology)-ийн үйлчилгээний чанарыг хэмжиж, функциональ байдал, тааламжтай байдал, аюулгүй байдал, загварлаг байдал, баталгаатай байдал, хялбар байдал, надад зориулж тохируулагдсан байдал гэсэн хэмжүүрээр тодорхойлон гаргалаа. Дээрх шалгууруудыг багтаасан асуулга судалгааг 151 хэрэглэгчээр үнэлүүлсэн бөгөөд энэхүү судалгаагаар өөрөө өөртөө үйлчлэх технологи (Self-service Technology)-ийн хамгийн чухал шалгуур нь хэрэглэгчийн сэтгэл ханамж (үнэнч хэрэглэгч) болохыг нотлов.

АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ:

1. Ajzen, I. (1985). From intentions to actions: A theory of planned behavior. In Kuhl, J. & Beckmann, J. (eds), Action control. Berlin, Heidelberg: SSSP Springer Series in Social Psychology. Springer. https://doi.org/10.1007/978-3-642-69746-3

2. Ajzen, I. (1991). The theory of planned behavior. Organizational
Behavior and Human Decision Processes, 50(2), 179–211. https://doi.org/10.1016/0749-5978(91)90020-T

3. Al-Alak, A. B. (2009). Measuring and evaluating business students satisfaction perceptions at Public and Private Universities in Jordan. Asian Journal of Marketing, 3(2), 33–51. https://doi.org/10.3923/ajm.2009.33.51

4. Anderson, R. E., & Swaminathan, S. (2011). Customer satisfaction and loyalty in E-Markets: A PLS path modeling approach. The Journal of Marketing Theory and Practice, 19(2), 221– 234. https://doi.org/10.2753/MTP1069-6679190207

5. Baron, R. M., & Kenny, D. A. (1986). The moderator–mediator
variable distinction in social psychological research: Conceptual, strategic, and statistical considerations. Journal of Personality and Social Psychology, 51(6), 1173. https://doi.org/10.1037/0022-3514.51.6.1173

6. Davis, F. D., Bagozzi, R. P., & Warshaw, P. R. (1989). User acceptance of computer technology: A comparison of two theoretical models. Management Science, 35(8), 982– 1003. https://doi.org/10.1287/mnsc.35.8.982

7. Davis, M. M., & Vollmann, T. E. (1990). A framework for relating
waiting time and customer satisfaction in a service operation. Journal of Services Marketing, 4(1), 61–69.
https://doi.org/10.1108/EUM0000000002506

8. Demirci Orel, F., & Kara, A. (2014). Supermarket self-checkout
service quality, customer satisfaction, and loyalty: Empirical evidence from an emerging market. Journal of Retailing and Consumer Services, 21(2), 118–129. https://doi.org/10.1016/j.jretconser.2013.07.002

9. Ding, D. X., Hu, P. J.-H., & Sheng, O. R. L. (2011). e-SELFQUAL: A scale for measuring online self-service quality. Journal of Business Research, 64(5), 508–515. https://doi.org/10.1016/j.jbusres.2010.04.007

10. Fernandes, T., & Pedroso, R. (2017). The effect of self-checkout
quality on customer satisfaction and repatronage in a retail context. Service Business, 11(1), 69–92. https://doi.org/10.1007/s11628-016-0302-9

11. Fornell, C., Johnson, M. D., Anderson, E. W., Cha, J., & Bryant, B.

E. (1996). The American customer satisfaction index: nature, purpose, and findings. Journal of Marketing, 60(4),7–18. https://doi.org/10.2307/1251898
12. Furrer, O., Liu, B. S.-C., & Sudharshan, D. (2000). The relationships between culture and service quality perceptions: Basis for cross-cultural market segmentationand resource allocation. Journal of Service Research, 2(4),355–371. https://doi.org/10.1177/109467050024004
13. Ganguli, S., & Roy, S. K. (2011). Generic technology-based service quality dimensions in banking: Impact on customer satisfaction and loyalty. International Journal of Bank Marketing, 29(2), 168–189. https://doi.org/10.1108/02652321111107648
14. Gounaris, S. P., Tzempelikos, N. A., & Chatzipanagiotou, K. (2007). The relationships of customer-perceived value, satisfaction, loyalty and behavioral intentions. Journal of Relationship Marketing, 6(1), 63–87. https://doi.org/10.1300/J366v06n01_05
15. Grewal, D., & Levy, M. (2009). Emerging issues in retailing Journal of Retailing, 85(4), 522–526. https://doi.org/10.1016/j.jretai.2009.09.007
16. Iqbal, M. S., Hassan, M. U., Sharif, S., & Habibah, U. (2017). Interrelationship among corporate image, service quality, customer satisfaction, and customer loyalty: Testing the moderating impact of complaint handling. International Journal of Academic Research in Business and Social Sciences, 7(11), 667–688.
17. Lin, J.-S. C., & Hsieh, P.-L. (2011). Assessing the self-service
technology encounters: Development and validation of SSTQUAL Scale. Journal of Retailing, 87(2), 194–206. https://doi.org/10.1016/j.jretai.2011.02.006
18. Loudon, D. L., & Della Bitta, A. J. (1993). Consumer behaviour.
Concepts and applications (4th Ed.). New York, NY: McGraw-Hill. Lovelock, C., & Gummesson, E. (2004). Whither services marketing? In search of a new paradigm and fresh perspectives. Journal of Service Research, 7(1), 20–41.
https://doi.org/10.1177/1094670504266131
19. Lovelock, C. H., & Young, R. F. (1979). Look to consumers to increase productivity. Harvard business review, 57(3), 168–178.
20. Makanyeza, C., Makanyeza, C., Chikazhe, L., & Chikazhe, L. (2017). Mediators of the relationship between service quality and customer loyalty: Evidence from the banking sector in Zimbabwe. International Journal of Bank Marketing, 35(3), 540–556.
https://doi.org/10.1108/IJBM-11-2016-0164
21. Martins, C., Oliveira, T., & Popovič, A. (2014). Understanding the
Internet banking adoption: A unified theory of acceptance and use of technology and perceived risk application. International Journal of Information Management, 34(1), 1–13.
https://doi.org/10.1016/j.ijinfomgt.2013.06.002
22. McGrath, C., & Astell, A. (2017). The benefits and barriers to
technology acquisition: Understanding the decisionmaking processes of older adults with age-related vision loss (ARVL). British Journal of Occupational Therapy, 80(2), 123–131. https://doi.org/10.1177/0308022616667959
23. Meuter, M. L., Bitner, M. J., Ostrom, A. L., & Brown, S. W. (2005).
Choosing among alternative service delivery modes: An investigation of customer trial of self-service technologies. Journal of Marketing, 69(2), 61–83.
https://doi.org/10.1509/jmkg.69.2.61.60759
24. Musso, F. (2010). Innovation in marketing channels: Relationships, technology, channel structure. Symphonya: Emerging Issues in Management, (1), 23–42
25. Norizan, K., & Nor, A. A. (2010). The effect of perceived service
quality dimensions on customer satisfaction, trust, and loyalty in e-commerce settings: A cross cultural analysis. Asia Pacific Journal of Marketing and Logistics, 22(3), 351–371.
26. Oh, H., Jeong, M., Lee, S., & Warnick, R. (2016). Attitudinal and
situational determinants of self-service technology use. Journal of Hospitality & Tourism Research, 40(2), 236–265.
https://doi.org/10.1177/1096348013491598



СИТИ Их сургууль
Веб сайт: www.citi.edu.mn
Холбоо барих утас: 77442244
И-мэйл: info@citi.edu.mn



Б.САЙХАНДЭЛГЭР
«СИТИ» Их сургуулийн Бизнесийн сургуулийн
Аялал жуулчлалын тэнхимийн III курсийн оюутан

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ
(Хустайн байгалийн цогцолборт газрын жишээн дээр хийсэн судалгаа)

Товч хураангуй

Хустайн байгалийн цогцолборт газар нь дэлхийн хамгийн ховор зүйл зэрлэг адуу-тахь (Equus ferus przewalskii Groves)-ийг сэргээн нутагшуулахаар байгуулагдсанаараа өвөрмөц онцлогтой. Энэ нутаг нь тахь сэргээн нутагшуулах үйл ажиллагаа эхлэхээс өмнө Төв аймгийн Аргалант, Алтанбулаг, Баянхангай сумдын малчдын өвөлжөө, хаваржааны бүс нутаг байсан юм. Анхны тахийг 1992 онд авчирч, 1993 онд Хустайн нурууг Нөөц газрын зэрэглэлээр улсын тусгай хамгаалалтад авсан бөгөөд 1998 онд Байгалийн цогцолборт газар болгон хамгаалалтын зэрэглэлийг нь ахиулсан.

Хустайн байгалийн цогцолборт газар нь төрийн мэдлийн газар нутгийг төрийн бус байгууллага хамгаалж, менежментийг нь хийдэг цорын ганц байгууллага байсан бол харин өдгөө төр-төрийн бус байгууллагын түншлэлийг өргөжүүлж, төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх болсон төдийгүй, өөр хоёр ч газрын хамгаалалтын менежментийг төрийн бус байгууллагад хариуцуулаад байна.

Хустайн байгалийн цогцолборт газрын менежментийг хэрэгжүүлж буй төрийн бус байгууллага орон нутгийн иргэдтэй хэрхэн хамтран ажиллаж, ямар үр дүн гарсан хийгээд нутгийн иргэдийн амьдралд тэр нь хэрхэн нөлөөлсөн болон иргэдэд тулгарч буй асуудлыг яаж шийдвэрлэж байгаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, менежментийг судлан, таниулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгаанд шинжлэх ухааны ерөнхий арга зүйн харьцуулалтын, дедукцийн болон ярилцлагын аргыг ашигласан.

Түлхүүр үг

Хустайн байгалийн цогцолборт газар, нутгийн иргэдийн оролцоо, орон нутгийн аялал жуулчлалын хөгжил

А. ХУСТАЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР, ТҮҮНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БҮС НУТГИЙН СУМДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны Зүйлийг авран хамгаалах комисс (Species Survival Commission)-ын Адуу судлаачдын баг (Equid Specialist Group) тус бүр 50-иас цөөнгүй үржлийн тахьтай, 250-иас багагүй тоо толгой бүхий 10 гаруй популяци бий болгохыг зорьж, энэ зорилгоор Монголд 3, Хятадад 3, Казахстанд 1 газарт тахь сэргээн нутагшуулах ажлыг эхэлсэн байдаг.

Энэ ажлыг эхлүүлснээр Монгол Улсын Засгийн газрыг Биологийн төрөл зүйлийн конвенцид нэгдэн орсон үүргийнхээ нэгээхэн хэсгийг нэр төртэй биелүүллээ хэмээн олон улсад үнэлэх болсон бөгөөд 1998 оны 7 дугаар сарын 1-нээс Голландын Засгийн газрын санхүүжилтээр уг төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Хустайн нурууны байгалийн цогцолборт газар 2001 онд байгуулагдсан ба төсөл хэрэгжүүлэх явцад хамгаалалтын захиргааг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх нь менежментийн хувьд оновчтой, эдийн засгийн хувьд ашигтай шийдэл болсон юм. Энэхүү төсөл нь бүс нутагт ядуурлыг бууруулах, малчин иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эерэг үр дүн үзүүлж байна.

Хустайн байгалийн цогцолборт газрыг байгуулах болсон зорилго нь энэхүү бүс нутгийн экосистемийг нутгийн иргэдийн идэвхтэй оролцоотойгоор унаган төрхөөр нь хадгалах, дэлхийд нэн ховордсон тахийг сэргээн нутагшуулж, байгальд зэрлэгээр бие даан амьдарч чадахуйц популяци бий болгох явдал юм. Тус бүс нутгийг тусгай хамгаалалтад авснаар жил ирэх тусам зэрлэг амьтдын амьдрах тааламжтай нөхцөл бүрдэж, үүнийг даган энд байсан байгалийн зэрлэг амьтдын тоо толгой, нягтаршил огцом өссөний дээр урьд байгаагүй амьтад ч нэмж ирэн идээшин нутагших болов.



Схем 1 (2019 оны байдлаар тоологдсон амьтдын тоо)

Иргэдийн оролцоотойгоор байгаль хамгаалах тулгуур үзлийн дагуу энэ бүс нутгийн иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулсан. Одоогоор өөр хоорондоо ялгаатай үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй бүлэг, нөхөрлөл ажиллаж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд «Байгалийн цогцолборт газрыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлнэ» гэж заасны дагуу байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлж, орлогоо байгаль хамгаалах ажилд зарцуулж байна. Эдгээр нь Хустайн нурууг улсын тусгай хамгаалалтад авсантай холбоотойгоор гарсан бодит үр дүн юм. Түүнчлэн энэ бүс нутгийн экосистемийн унаган төрхийг хамгаалан хадгалж, дэлхийд нэн ховордсон зэрлэг адуу-тахийг сэргээн нутагшуулж, байгальд бие даан амьдрах чадвартай популяци бий болгосон, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэн, түүнд түшиглсэн санхүүгийн тогтвортой эх үүсвэртэй болсон зэрэг олон эерэг үр дүн бий болжээ. Мөн нутгийн иргэдийн идэвхтэй оролцоотойгоор Хустайн байгалийн цогцолборт газар, түүний орчны бүсийг хамгаалах боломж бүрдээд байна.



Схем 2 (Хустайн байгалийн цогцолборт газрын хөгжлийн цикл)

[1] Хустайн байгалийн цогцолбор газрын 2017 оны үйл ажиллагааны тайлангаас.
[2] 2002 онд Хустайн нурууны байгалийн цогцолбор газрыг Монгол Улсын Засгийн газраас хамгийн сайн тусгай хамгаалалттай нутаг хэмээн үнэлсэн байдаг.

Энэхүү цикл нь Хустайн байгалийн цогцолборт газрын өнөөдрийн хөгжилд хүргэсэн. Тус газрын хувьд байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд юуны түрүүнд байгалиа онгон дагшнаар нь урт удаан хугацаанд хамгаалах, түүний тулд нутгийн иргэдийн оролцоо дэмжлэгийг авах шаардлагатай болжээ. Энэ нь эргээд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд түлхэц болсон. Хустайн байгалийн цогцолборт газрын экосистемийг тогтвортой хадгалан хамгаалахын тулд орон нутгийн иргэдийг дэмжин ажиллахыг гол зорилгоо болгосон менежментийн бодлогыг Голландын Засгийн газар дэмжин санхүүжүүлж, тус аймгийн нутаг дэвсгэрт хэд хэдэн үйлдвэр байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.

Бүс нутгийн эдийн засгийн үзүүлэлт, хамтын ажиллагаа

Хүснэгт 1. Хустайн цогцолборт газрын орчны бүсэд хамрагдах сумдын ерөнхий мэдээлэл

Сум	Аргалант	Алтанбулаг	Баянхангай
Нутаг дэвсгэр /км²/	5566 /км²/	1200 /км²/	1010 /км²/
Хүн амын тоо	3452	1929	1644
Сумын төвийн хүн ам	909	673	416
Эдийн засгийн үндсэн салбар	Мал аж ахуй	Мал аж ахуй Газар тариалан	Мал аж ахуй Газар тариалан
Ядуу өрхийн эзлэх хувь	24.4	19.6	28.4
Малын тоо /мян толгой/	110.4	17.0	47.9
Газар тариалангийн талбай /га/	126 /Ашиглагдаагүй талбай 1200/	14515	11000
Боловсрол	10 жилийн дунд сургуультай	10 жилийн дунд сургуультай	10 жилийн дунд сургуультай
Эдийн засгийн бусад салбар	Бяслагны үйлдвэр “Их булаг” худалдааны төв “Таван очир” мал эмнэлэг	Гуанз Ямааны аж ахуй Сүүний үйлдвэр	Засмал замын дагуух гуанз Спирт, эмийн үйлдвэр Тарагны үйлдвэр
Хустайн цогцолборт газрын бүс нутгийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа болон өөрчлөлтүүд			
Орчны бүсийн 3 суманд Орчны бүсийн зөвлөл (ОБЗ), Орчны бүсийн нэгдсэн зөвлөл байгуулагдсан. Сумдын ОБЗ тус бүр өөртөө 23-25 сая, ОБНЗ 300 гаруй сая төгрөг бүхий орчны бүсийг хөгжүүлэх сантай болж, орчны бүсийн иргэдэд хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж олгох зэргээр малчдын амьдралыг дээшлүүлэх, байгаль хамгаалахад санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Өнгөрсөн 20-иод жилд 334.7 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 509.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Нийт 1 тэрбум гаруй төгрөгийн тусламж үзүүлсэн.	Сумдын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дэргэд сургалтын танхим байгуулж, уг танхимд үйл оёдол, талх, нарийн боов хийх, хивс нэхэх зэрэг сургалтууд зохион байгуулж, ажилтай иргэдийн тоо өссөн.	Орчны бүсийн гурван сумын хүн эмнэлгийн барилгыг засварлах, халаалтын системийг шинэчлэх, түргэн тусламжийн машин авч өгөх, төрөхийн өмнөх байрыг тохижуулах зэрэг ажлыг хийсэн. Эмийн сангийн эргэлтийн нөөц бий болгосон.	“Орчны бүсийн эмэгтэйчүүд”, “Орчны бүсд эмнэлэг, эрүүл ахуйн үйлчилгээг сайжруулах” зэрэг дэд төслүүд хэрэгжүүлсэн. Малчдын 34 бүлэг, эсгий эдлэл хийдэг 5 бүлэг байгуулагдан уламжлалт аргаар эсгий ширмэл эдлэл хийхээс гадна орчин үеийн шинэ технологи эзэмшин төрөл бүрийн бэлэг дурсгалын зүйлс үйлдвэрлэн дотооддоо борлуулах төдийгүй гадаадад экспортолж байна.

Б. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дэлхийд ховордсон зүйл болох зэрлэг адуу-тахь, байгалийн цогцолборт газрын онгон зэрлэг байгаль, монгол ахуй, соёл, уламжлал, олон зүйлийн амьтад, ургамал гэх мэт сонирхол татах олон зүйл нь Хустайн байгалийн цогцолборт газарт ирэх жуулчдын тоо нэмэгдэхэд нөлөөлж байна. Жуулчдын тоо өсч байгаа нь бүс нутгийн иргэдийн амьжиргаанд чухал нөлөө үзүүлж байна[3].

Хүснэгт 2. Сүүлийн 7 жилийн жуулчны тоон харьцуулалт

Он	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Гадаад	9386	10177	10383	12452	15046	16448	18880
Дотоод/орчуулагч жолооч	6638	7319	8097	8819	9723	10580	12832
Хустайн жуулчны базаар үйлчлүүлсэн хоноглосон						7636	8332
Нийт дүн	16024	17496	18480	21271	24769	27028	31712

Хустайн байгалийн цогцолборт газартай орон нутгийн иргэд хэрхэн ашигтай хамтран ажиллаж байгааг дараах үзүүлэлтүүдээс харж болно:

Хүснэгт 3. Монголд ирсэн нийт жуулчид болон Хустайн цогцолборт газрын орчны бүс дэх малчин өрхөөр зочилсон жуулчдын тоон дүн[4]

Жуулчдын тоо	2018	2019
Монгол Улсад зорчсон гадаад жуулчид /нийт/	529370	577300
Үүнээс Хустайд ирсэн	16448	18880
Эзлэх хувь	3.1%	3.5%
Орон нутгийн айлуудаар зочилсон, дэмжсэн	*150+226+ 447+650=1473*	*1000+350 +70+300=1720*
Эзлэх хувь	*8.9%*	*9.1%*

Дээрхээс үзэхэд гадаадаас манай улсыг зорин ирж буй жуулчдын тодорхой хувь нь Хустайн цогцолборт газрыг заавал зорьж очдог болжээ. Харин 2018 онд малчин айлд зочилсон нийт хүний тоог, нэг хүний малчин айлд зочлохдоо төлбөл зохих үнийн дүнгээр /30,000₮/ тооцвол 44,190,000₮, 2019 онд 51,600,000 төгрөг болж өссөн байна. Энэ нь зөвхөн малчдын гар дээр ирж буй орлого юм.



Хүснэгт 4. Орчны бүсийн өрхийн амжиргааг нэмэгдүүлэх зорилгоор зөвхөн аялал жуулчлалаас нэг жилийн орлогоос иргэдэд олгосон хөнгөлттэй зээлийн хэмжээ

№	Нөхөрлөлийн нэр	Үйл ажиллагаа	Гэрээт компани	Үйл ажиллагаа	Жилд хүлээн авдаг дотоод, гадаад жуулчдын тоо	Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа
1	Сэртэн бүлэг	НИТАЖ-ын нөхөрлөл	2 тур оператор	Бэсрэг наадам	300	10 жил
2	Мандал бүлэг	НИТАЖ-ын нөхөрлөл	3 тур оператор	Үхэр тэргэн аялал	100-250	12 жил
3	Эко хөгжил	НИТАЖ-ын нөхөрлөл	6 тур оператор	Эко шийдэл	350-450	3 жил
4	Баян сонгинот	НИТАЖ-ын нөхөрлөл	11 тур оператор	Хонины найр	1000-1100	17 жил

Хүснэгт 5. Малчдын нөхөрлөлүүдийн аялал жуулчлал эрхэлж буй байдал

Хустайн байгалийн цогцолборт газартай хамтран ажиллаж буй бүлэг, өрх айлууд болон жуулчны баазын ажилчдын 71% нь энэ бүс нутгийн сумдын иргэд байна. Тэдний 43% нь 10-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮР ШИМИЙГ НУТГИЙН ИРГЭД ХЭРХЭН ХҮРТЭЖ БУЙ ТУХАЙ

Тус бүс нутгийн 3 сумын иргэдийн амьжиргаа болон малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж, дараах хөрөнгө оруулалтыг хийж байна.

№	Бараа, бүтээгдэхүүн	Тоо, ширхэг	Нийт	Хаанаас
1	Талх, боов боорцог		900,000 ₮	Аргалант сум, талхны цех
2	Алтанбулаг бяслаг	796 кг	9,550,000 ₮	Алтанбулаг сум, “Лигийн ухаа” ХХК
3	Хонь, ямааны мах		2,260,000 ₮	3 сумын иргэд
4	Үхрийн мах	2854,8	24,429,600 ₮	3 сумын иргэд
5	Адууны мах		49,000 ₮	Алтанбулаг сумын иргэд
6	Сүү	194 л	363,500 ₮	Сэртэн бүлэг
7	Сүү	15 л	12,000 ₮	Алтанбулаг сум
8	Зөгийн бал	71 ш	1,188,000 ₮	Сэлэнгэ аймаг
9	Тараг	480 л	960,000 ₮	Сэртэн бүлэг
10	Өргөст хэмх, лууван		424,900 ₮	Алтанбулаг сум, Хад
11	Хүнсний ногоо		80,360 ₮	Алтанбулаг сум, Хад
Нийт			**40,217,360 ₮**	

Хүснэгт 6. Нутгийн иргэдээс худалдаж авсан бүтээгдэхүүний жагсаалт /2019 он/

[3] Баатарцоож.Г. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын эдийн засгийн шинжилгээ. УБ., 2010.
[4] Хустайн байгалийн цогцолбор газрын 2019 оны үйл ажиллагааны тайлангаас.

Дээрх судалгаанаас 1 жилийн хугацаанд бүс нутгийн иргэдээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүн, тэдний орлогын дүнг харж болно.

1	**Сайн дурын ажилтан**	472,560 ₮	Алтанбулаг сум, Баянсонгинот бүлэг
2		195,000 ₮	Эко хөгжил бүлэг-Ганчулуун
3		585,000 ₮	Тост бүлэг
4		170,000 ₮	Эко хөгжил бүлэг-Батхишиг
5	Гэрийн өрх 32 ш хийлгэхэд	1,024000 ₮	Алтанбулаг сум, Баянсонгинот бүлэг
Нийт		2,446,560 ₮	

Хүснэгт 7. Сайн дурын ажилчдын оруулсан орлого

Жил бүр гадаад, дотоодын сайн дурын ажилчид Хустайн байгалийн цогцолборт газарт судалгаа хийх болон бусад шалтгаанаар 3-7 хоногоор ирж, малчин айлд байрлаж ажилладаг. Энэ нь малчдын орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг байна.

	2018	**2019**
Нэр, төрлийн тоо	32 төрөл, 247 ш	52 төрөл, 652 ш
Орлого	1,773,950 ₮	1,776,500 ₮

Хүснэгт 8. Бэлэг дурсгалын дэлгүүрт борлуулсан бүтээгдэхүүн

Хамтран ажиллаж буй иргэд, үйлдвэрийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор тэдэн рүү чиглэсэн бодлого, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, тур оператор компаниудтай хамтран сургалт зохион байгуулж байна. Тухайлбал, гар урлалын зүйл хийх, цагаан идээ боловсруулах, гадаад хэл сургах, байгаль хамгаалах, арчилгаа гэх мэт сургалтын үйл ажиллагаа тогтмолжсон байна.

Цаашид айл өрхүүдийн орлого олох боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор нутгийн иргэдийн хийсэн гар урлал, эсгий тоглоом, арьсан эдлэл, бэлэг дурсгал, ноосон эдлэл зэрэг бүтээгдэхүүнийг Хустайн цогцолборт газрын нэрийн дэлгүүрээр борлуулах, гадаадад экспортлох зэргээр зах зээлийг нь өргөжүүлэх ажлыг хийхээр төлөвлөсөн байна. Малчид зөвхөн мал аж ахуйгаас үндсэн орлогоо олдог байсан бол Хустайн байгалийн цогцолборт газартай хамтран ажилласнаар олон төрлийн сургалтад хамрагдаж, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэн, амьдралын түвшин нь дээшилж байна.

Хустайн байгалийн цогцолборт газартай хамтарч ажилласнаар орон нутгийн иргэдэд үзүүлж буй эерэг нөлөөлөл:

- Орон нутагтаа илүү тогтвортой суурьших;
- Олон улсын соёл, стандартаас суралцаж хөгжих;
- Хөнгөлөлттэй зээлд хамрагдах, түүгээрээ бизнес эрхлэх;
- Малчид нэгдэн хоршиж ажилласнаар амьжиргааны түвшин дээшлэх;
- Байгаль хамгаалах үйлсэд гар нийлж нэгдэн оролцох;
- Ажлын байраар хангагдах зэрэг олон давуу талууд бий болж байна.

ДҮГНЭЛТ

1.Тусгай хамгаалалттай газар нутгийг бий болгосноор тахийг сэргээн нутагшуулах ажил амжилттай болж, дэлхийд нэн ховордсон тахийн бие даан амьдрах чадвартай популяци бий болсон. Энэ нь тогтвортой аялал жуулчлал хөгжих нэг чухал нөхцөл болсон гэж үзэж болохоор байна.

2.Нутгийн иргэдийн идэвхтэй оролцоотойгоор тусгай хамгаалалттай газар нутгийн эко системийг тууштай хамгаалах боломж бүрдсэн.

3.Жуулчид зөвхөн тахь үзэх гэж биш, байгалийн цогцолборт газарт байгаа бусад ховор зэрлэг амьдыг ойроос харах, монгол айлд зочлох, монгол ахуй, соёлыг таньж мэдэх гэж ирдэг болжээ. Тусгай хамгаалалттай газрын захиргаа ч нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, тэднийг жуулчлалын үйлчилгээний үйл ажиллагаанд татан оролцуулах нөхцөл бүрдсэн байна. Энэ нь эргээд тэдний амьжиргаанд ээрэг нөлөө үзүүлж байна гэж үзэж болно. Дээрх үйл ажиллагаа нь байгальд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчлалд зориулсан бараа, бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэх маш их боломж нөөц байгааг харуулж байна.

4.Малчид, жуулчны тур операторууд хамтран ажилласнаар монгол өв соёл сэргэх, цаашид уламжлан хадгалах үйл ажиллагаа идэвхжиж, байгалиа сэргээн хамгаалах, ховор амьтдын тоо толгой өсөхөд чухал нөлөө үзүүлж байна.

5.Байгалийн цогцолборт газраас явуулж буй олон талт үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдэд ихээхэн дэмжлэг болж, орон нутгийн эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хустайн байгалийн цогцолборт газраас авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны менежмент, хөтөлбөрийг Монгол Улсын тусгай хамгаалалттай бусад бүх газар нутагт хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Энэ нь иргэдийн оролцоотой байгалиа хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих циклийг бий болгоход чухал алхам болно.

АШИГЛАСАН НОМЫН ЖАГСААЛТ:

I.Монгол эх сурвалж

- Баатарцоож.Г., Алтанзул.Б. Тогтвортой аялал жуулчлал. УБ., 2005.
- Баатарцоож.Г. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын эдийн засгийн шинжилгээ.УБ., 2010.
- Билэгсайхан.М, Цогбадрал.Х, Амаржаргал.С, Адъяасүрэн.Ц. Тогтвортой аялал жуулчлал. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага. «UNWTO» сэтгүүл. 2016.
- Гантөмөр.Д. Жуулчны зорих газрын менежментийн төлөвлөгөө. УБ., 2019.
- Хятадын дархан цаазат газрын эко менежмент. Шведийн шинжлэх ухааны академи. Стокголм., 2001.
- Хустайн байгалийн цогцолборт газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан.
- Хустайн байгалийн цогцолборт газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан.
- Хустайн байгалийн цогцолборт газрын 2019 оны үйл ажиллагааны тайлан.
- www.hustai.mn

II.Гадаад эх сурвалж

- Gantumur.D, Issues and challenges of Sustainable Tourism development in Mongolia. UB., 2019.
- Sutresna Ida Bagus. Community based tourism as Sustainable tourism support. Indonesia 2019.
- Yemen, A.R. and Mohd A. Community Based Eco-Tourism: New Proposition for Sustainable Development and Environment Conversation. Malaysia., 2004.



СИТИ
СИТИ ИХ СУРГУУЛЬ

СПОРТ ДУГУЙЛАН



- Сагсан бөмбөг
- Хөл бөмбөг
- Волейбол
- Шатар
- Даам
- Ширээний теннис
- Газрын теннис
- Иога, бясалгал
- Бүжгийн спорт
- Фитнесс клуб
- Карате
- Жүдо
- Бадминтон
- Явган аялал
- Таеквондо
- Кэндо

БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР:

www.citi.edu.mn сайтад нэвтэрч СИТИ СПОРТ цэс рүү орж Спорт клуб, дугуйланд бүртгүүлэх хэсэг рүү шилжин өөрийн сонирхож буй спортын дугуйланд бүртгүүлэх боломжтой.

Д.САНДАГСҮРЭН
«СИТИ» Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/

ЗАЛУУЧУУДЫН ЗАН СУРТАХУУНЫ ТӨЛӨВШЛИЙН БАЙДЛЫГ АЖИГЛАХУЙ

Оршил

Гэрийн юм уу, цахилгаан шатны хаалгаар ахмад хүнээ эхэлж оруулна, гаргана. Хаалган дээр хоёр хүн таарахад «олз нь эхлээд орог, гарз нь дараа нь гараг» гэж билгэшээн орох нь эхэлж ороод, гарах нь дараа нь гарна. Настай хүн айлд ирвэл мориных нь жолоог барьж, түшиж буулган гэртээ урина. Явахад нь моринд нь мордуулж өгнө. Бидэнд ахмадаа хүндэтгэх энэ мэт олон сайхан хүмүүжил байсан. Гэтэл одоо... Автобусанд сууж ядаж буй настай хүнийг сурагчийн цүнх үүрсэн хүүхдүүд бараг л дайрч унагачихаад орж байна. Автобусны буудал дээр хэдэн минут болоход тамхи баагуулсан хэдэн банди шүлсээ хаясаар тэр хавийг нэлд нь ой гутмаар болгохыг хараад тэсгэл алдана. Санаандгүй тохойгоороо ёворч орхивол «Аятайхан байгаараа, ах аа» хэмээн эвгүй хялайна. Жаахан үг сөрвөл «Хэд хоног амьд явахаа бод» хэмээн амь насанд заналхийлэх нь энүүхэнд. Хашааны булан, хүн багатай гудманд морь харж буй согтууд үг хэлвэл хэлснээсээ эс юм болж мэднэ. Их хотын автозамд эрүүл стрессгүй нэг өдөр битгий хэл хэдэн хором явахад ч хэцүү. Нэг л их яарсан адгасан, уцаарласан, ууртай догшин хүмүүс. Монгол хүн ийнхүү «танигдахын» аргагүй өөрчлөгдөж байна. Шинэ нийгмийн залуучуудын зан төлөвийг одоогоос 30-аад жилийн өмнөх үетэй харьцуулбал энэ мэт ихээхэн өөр дүр зурагтай байна. Энэ бүгд юунаас болсон юм бол? Энэ талаар өөрийн ажиглалт дээр үндэслэн зарим нэг дүгнэлт хийхийг зорилоо.

Түлхүүр үг

Ёс зүй, төлөвшил, амиа хичээх, эрхэмлэл, шинэ хандлага, индивидуализм, соёлын модернизаци, зөөлөн хүчний нөлөөлөл, нийтийн соёл, гэр бүлийн хүмүүжил, либерал соёлын үнэт зүйл

А. ХУУЧИН НИЙГМИЙН ТӨЛӨВШИЛ

Чөөхөн жилийн дотор Монголын залуучууд зан суртахууны хувьд ийнхүү «төрөл арилжсан» нь нийгмийн учир шалтгаантай юм. 1990 оны ардчилсан хувьсгалаар төрийн хуучин тогтолцоог халахад коммунист үзэл суртал, социалист аж төрөх ёс гээд тэр үеийн нийгмийн амьдралын тогтсон хэв маяг бүгд хамт нуран унасан билээ. Хуучин тогтсон хэм хэмжээний оронд шинэ хэм хэмжээ, шинэ хандлага, шинэ тогтолцоо бүрэлдэн төлөвших учиртай байв. Үүнд цаг хугацаа хэрэгтэй. Нийгмийг тогтворжуулж байдаг, хэвийн амьдрахад нь шийдвэрлэх үүрэгтэй нэгтгэн нягтруулагч үзэл суртал, хуулийн болоод ёс суртахууны хэм хэмжээнүүд үнэ цэнэгүй болоод ирэхээр нийгэм ямар ч зохицуулалтгүй, эмх замбараагүй болдог аж. Нийгмийн эмх замбараагүй байдал нь хүүхэд, залуучуудын нийгэмшил, биеэ авч явах байдалд сөргөөр нөлөөлж, гажууд зан төлөв ихсэхэд нөлөөлдөг байна. 1990 оны хувьсгалтай хамт социалист аж төрөх хамтач ёс, хэвшиж тогтсон хэм хэмжээ асар богино хугацаанд илбийн мэт алга болов. Ийнхүү хүн хүндээ нөхөр, нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийн төлөө гэх мэт ах дүүгийн барилдлагат харилцаа үгүй болжээ.

1990 оны ардчилсан хувьсгалын дараа эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, үйлдвэрлэх эрхийг чөлөөтэй тавьж өгснөөр эд материалын төлөөх улайрал уралдаан эхэлсэн байдаг. Ямар ч аргаар хамаагүй баяжих хөлжих гэсэн эд хөрөнгийг дээдлэх сэтгэлгээ газар авсан. Үүнээс үүдэн хувиа хичээх, амиа борлуулах, шуналтай, дээрэнгүй бэртэгчин зан ихсэж, хуулиар хориглоогүй бол юу ч хийж болно гэсэн сэтгэхүй газар авчээ.
Хүн өглөө босоод л нийгмийн харилцааны хэм хэмжээний хил хязгаарт ордог. Хүний харилцааны хамгийн анхны хэм хэмжээ нь мэндлэх хүндлэх ёс юм. Хүн тааралдсан хүнтэйгээ зөв үг хэллэгээр, төв сайхан хоолойгоор мэндчилэхэд хариу мэндчилгээ нь мөн зөв эерэг сайхан сэтгэгдэл төрүүлэхүйц байх нь ойлгомжтой. Элдэг дөлгөөн зантай, зөв сайхан үйлтэй, хүнд тустай, баян, ядуу хэнийг ч алагчлалгүй үздэг гэгээлэг хүн байдаг. Мөн их зантай, дээрэнгүй, өөрийгөө дөвийлгөсөн, ихэмсэг харилцаатай хүн ч тааралддаг. Хүний харилцааны энэ бүх хэм хэмжээний нийлбэр нь тэр хүний ёс суртахууны хэр хэмжээг илтгэдэг байх юм.

Ер нь ёс суртахуун гэж юу юм бэ? Ёс суртахуун гэдгийг аливаа зүйлийн дунджийг тааруулах гэж товчхон хэлж болно. Юм бүхэн хэр хэмжээндээ байх ёстой. Хүүхдэд хайр хэтэрвэл эрхээрээ хатна, хал хэтэрвэл догшин хэрцгий болно. Эд баялгаар дутаахгүй гэсээр байгаад хүүхдээ хөрөнгө мөнгөний шуналтай болгодог. Дэвийн гэмээр шуналтай болсон хойно нь хичнээн хэлээд тэр хүний буруу зан араншинг засах боломжгүй. Буруу өссөн хүүхэд бухын хүзүүнээс хатуу гэж үүнийг хэлсэн байж таарна.
Манай залуучууд гадаад, дотоодод их, дээд сургууль төгсөж, өндөр боловсрол эзэмшдэг ч, энэ нь тэднийг өндөр ёс суртахуунтай гэсэн үг хараахан биш юм. Өндөр боловсролтой боловч ёс суртахуунгүй хүн байдаг. Хүн дээд боловсролгүй байж болно, бас хөрөнгө мөнгөгүй ч байж болно, гагцхүү хүн чанартай байх ёстой. Зовж шаналсан нэгэнд хүргэх хариу нэхээгүй тус бол хүн чанар юм. Гудамжинд төөрүүлсэн гөлгийг хүйтэнд хөлдөх аюулаас авран дулаан байр барьж өгөх нь хүний нинжин сэтгэл юм. Зөв сэтгэлтэй хүнээс зөв үйл гардаг. Хэн нэгэн өвдөхөд хандив тус өгөх, гудамжны амьтанд туслах, найз нөхөд зовох үед дэргэд нь байх зэрэг нь хүмүүсийн сэтгэлээс гардаг зөв үйлдэл юм. Энэ бол сайхан сэтгэл, өгөөмөр зан чанар юм. Тэгэхээр хүний хөгжлийн дээд оргил нь өндөр боловсрол биш, хүний өөрийнх нь хүмүүжил байх нь. Гэтэл бид ардчиллын гэх энэ хэдэн жилд хүний эрх, эрх чөлөөг ханатал ярьсан атлаа хүнийг хүн болгодог хүмүүжлийн асуудлыг мартаж орхисон нь хөгжлийн хоцрогдлын эх үндэс нь болжээ гэж дүгнэхэд хүрч байна.

Б. ШИНЭ НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ТӨЛӨВШИЛ

Индивидуализмыг гол суртлаа болгодог либераль үзэл гэдгийг амиа хичээх гэж шууд орчуулан ойлгох болов. Уул нь баруунд дундаж давхаргыг өөгшүүлэн хөгжүүлснээр нийгмийн сайн сайханд хүрнэ гэж томьёолдог. Нийгмийн дундаж давхаргын хүмүүс хэнээс ч хараат бус амьдардаг. Тэд төрөөс ч, бусдаас ч юу ч гуйхгүй оршин тогтнож чадна. Өөрөөр хэлбэл, тэд «амиа борлуулж, довоо шарлуулдаг» гэсэн үг. Амиа хичээх, амиа борлуулах хоёр бол уул нь хоёр өөр зүйл. Би л болж байвал бусад нь хамаагүй гэдэг нь «довоо шарлуулах» биш, харин амиа хичээх үзэгдэл юм.

Одоогийн нийгэмд хүн хөдөлмөрлөхгүй байж болно, хөдөлмөрийн бус орлогоор амьдарч болно, биеэ үнэлж болно. Залуучуудын архидалтыг хориглож хэн ч чадахгүй байна, гэр бүл салалт ердийн үзэгдэл болсон, хүнийг хууран мэхлэх, залилах бол байдаг л зүйл, арилжаа наймаа нь зарим нэгний хувьд энэ нийгэмд амьдрах бараг цорын ганц арга болов. Мөрийтэй тоглох, хээл хахууль өгөх, авах, өмч хөрөнгө идэх

шамшигдуулах, хууль бусаар хөрөнгөжих, хар тамхинд мансуурах, наймаалах гэдэгтэй бид бүр эвлэрсэн. Хуучин нийгмийн хэм хэмжээ нуран унасны дараах 30 жилд бидний хэвшүүлж тогтоож буй зан суртахууны хэм хэмжээ маань ийм байна. Нийгмийн өөрчлөлттэй хамт монгол хүний эртний сайхан зан чанар болох хүнлэг энэрэнгүй сэтгэл, шударга ёс, бие биедээ туслах зан, эв эеийг хичээх ёс, ахсаа хүндлэх, дүүг энэрэх ухаан улам бүр гээгдэн алга болж байна. Тийм ч учраас хүний мөс муудлаа, залуучууд ёс суртахуунгүй болжээ гэж ахмад үеийнхэн шүүмжлэн хэлэлцэх нь зүй.
Хамтач аж төрөх ёс яагаад ийм амархан нуран унав гэж зарим хүн гайхан эргэлздэг. Энэ нь нийгмийн тодорхой учир шалтгаантай ажээ. Өмнөх социалист нийгмийн эрхэмлэлүүд нь гаднаас, дээрээс тулгасан, хувь хүнийг нийгэм төрд захируулж, хүний эрх чөлөөг хаан боогдуулж байсан учраас тэдгээр нь социализмын сүйрэлтэй хамт амархан гээгдсэн байна. Хүчээр тулгасан, хүчээр барьж байсан, өөрийнх нь элгэнд үрсэлж бойжоогүй зүйл хүний үйл хөдлөл, зан байдалд хэвшиж тогтдоггүй, салхинд хийсэх мэт нэг л өдөр алга болдог аж. Социалист аж төрөх ёсны оронд барууны либераль соёлын эрхэмлэлүүд болох ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, зах зээл, чөлөөт өрлсөлдөөн зэрэг үнэт зүйлс төлөвшин тогтох ёстой байв. Гэтэл хувийн үйлдвэрлэл, өмчийг зөвшөөрснөөс хойш эд материалыг шүтэх, амиа хичээх, хялбар аргаар баяжих гэх мэт гаж үзэгдлүүдийг бид хэвийн ердийн зүйл мэт хүлээн авдаг болсон нь дээрх хямралын нэг илрэл байв.

Ёс суртахуун ялзрахаар улс орны хөгжил доройтдог. Хөгжил хоцрогдож ирэхээр ёс суртахуун ялзарч ирдэг. Эдгээр нь харилцан хамааралтай ойлголт юм. Энэхүү ялзрал нь нийгмийн ихэнх хэсгийн зан төлөв болох шударга бус, аймхай, зориггүй, ханаж цадахгүй шуналтай, нэр төрөө шороотой хутгадаг зэрэг дунджаас хэлбийсэн гаж байдлаар илэрдэг байна. Ардчилал, хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн шинэ нийгмийг хөгжүүлэн төлөвшүүлэх үйл явц өрнөсөн 1990 оноос хойших 30 шахам жилд хүний хувьд авч үзвэл бүхэл бүтэн нэг үе хүмүүжин төлөвшжээ. Энэ үед бид хүүхдийн эрх, хүний эрх, эрх чөлөө гэж их ярьсан. Харин шинэ тогтсон нийгмийн үнэт зүйл, эрхэмлэлийн талаар тун бага ярьжээ. Ардчилал, хүний эрх гэхээр бүгд сайн ойлгодог. Харин монгол хүний зан төлөв, ёс заншил, уламжлалт соёл гэдгийг нийгэмд ухамсарлуулж, түүнийгээ шинэ нийгмийн үнэт зүйлээр баяжуулан хөгжүүлэх асуудлыг гаргуунд нь хаяснаас хүүхэд, залуучуудын хүмүүжил гажуудан залуучууд маань «огт танигдахааргүй» хүн болон төлөвшиж байна. Энэ шилжилтийн үеийн монгол хүнийг тодорхойлбол: биеэ тоосон, амиа хичээсэн, дээрэнгүй бардам, эд мөнгөний шуналтай, адгасан уурласан түргэн зантай гэсэн зан байдлын төлөв гарч ирж байна. Энэ бол ардчилсан Монголын шинэчлэл өөрчлөлт хийсэн 30 жилд бидний хүмүүжүүлсэн шинэ монгол хүний дүр төрх юм.

Улаанбаатарын гудамжаар нэг л их ууртай, ширүүн төрхтэй, яарсан адгасан, шазруун шаралхуу хүмүүс дүүрэн. Сэрэмж алдаад жолоогоо эвгүйхэн дарсны төлөө урдуур хойгуур хөндөлсөн хариу үйлдэл үзүүлэх, эсвэл жаахан шахуулсандаа шаралхан бууж ирээд заамдах залуучууд захаас аван зөндөө. Улаанбаатарын залуучууд яагаад ийм сагсуу, ойворгон, дээрэнгүй болчиов оо? Монголчууд бид бие төрмөл ухаан таримал гэж ярьдаг даа. Тэгэхээр бид зөв ухааныг тарьж чадсангүй, зөв ёсыг сэтгэлд нь ургуулж чадсангүй. Уул нь зөв сэтгэлтэй хүнээс зөв хандлага, зөв үйлдэл гардаг. Чингис хаан «хүний сэтгэлийг эзэл, тэгвэл бие нь хаачих вэ» гэж хэлсэн байдаг. Тийм учраас хүний сэтгэлтэй нь ажиллах ёстой байж. Бид өнгөрсөн энэ жилүүдэд залуучуудынхаа «сэтгэлийг эзэлж» чадсангүй.

Хүнийг хүн ёсоор хүндлэн харилцах нь барууны нийгмийн хамгийн наад захын харилцааны хэм хэмжээ билээ. Тэнд хүн ядуу байх, хөрөнгөгүй байх, боловсролгүй байх нь энэ харилцаанд нөлөөлдөггүй. Гэтэл одоогийн залуучууд хүнийг өмссөн зүүсэн, эдэлсэн хэрэглэснээр нь ялгаварлан харилцах нь ерийн үзэгдэл. Хүнийг унасан машин, барьсан утас, зүүсэн цаг, гэр, байшинд амьдардаг, тэр ч битгий хэл хотын аль дүүрэгт суудаг гэдгээр нь ялгаварлан харилцах хэм хэмжээ бий боллоо. Зайсан хавиар гэртэй, «Бенз», «Ланд» унасан хүнтэй нэг өөр, Чингэлтэй, Шархад хавиар гэртэй, эсвэл «Приус», «амьжиргаа цагаан» унасан хүнтэй арай нэг өөр өнгөөр харилцаад байгааг хэн хүнгүй л анзаардаг. Ийм харилцаанд бид аль хэдийнэ дасчээ. Уул нь ардчилсан нийгэмд хүн хэн байх нь хамаагүй, хамгийн гол нь хүн гэдэг утгаар нь харилцах учиртай. Хэн ч байлаа гэсэн хүндэтгэн харилцаж, инээмсэглэн угтаж, элдэг зангаар үдэх гэдэг нэг л хэм хэмжээ үйлчилдэг.
Хотын орон сууцны нэг давхарт өчнөөн жил зэргэлдээ хаалганд амьдрах мөртлөө хөрш айлынхаа хүмүүсийг зүс танихаас нэрийг нь ч мэддэггүй. Гэтэл бидэнд «саахалт айлын санаа нэг, хот айлын хоол нэг» гэсэн сайхан уламжлал байсан. Хэн нэгний адуу хол явсан бол дөхүүлээд өгдөг, худаг дээр хэдэн мал нь ирж таарвал услаад гаргадаг, айл нүүж байвал ачаалаад өгдөг, саахалт айл хонио ноосолж байвал хэдэн

хонины хөл боогоод өгдөг бие биедээ тусархуу сайхан сэтгэлтэй ард түмэн билээ. Гагцхүү энэ уламжлалыг хүүхэд залуучуудын ухаанд суулгах, сургах ажил ихээхэн хоцорчээ.

В. ГАДНЫ ОРНЫ ТУРШЛАГА

Орчин үед хүн ардынх нь ёс суртахуунаар улс орны хөгжлийг хэмждэг, хаана өндөр ёс суртахуун байна тэнд хөгжил цэцэглэл буй болдог гэж ярьж бичдэг болжээ. Байгалийн ямар ч баялаггүй мөртлөө Япон улс дэлхийн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх орон болсон төдийгүй, хамгийн өндөр ёс суртахуунтай улс болжээ. Энэ юутай холбоотой юм бол? Тэд юуны өмнө хүмүүсийн оюун санааны эрхэмлэлийн эх үүсвэрийг самуурайн ёс зүйгээсээ олж авчээ. Самуурай хүн хамгийн шударга, үнэнч, сэтгэлийн хаттай, тэсвэр тэвчээртэй, энэрэнгүй, ажилсаг, нэр төрөө эрхэмлэдэг байх ёстой гэж үздэг. Монголчууд бид Акира Курасовагийн бүтээсэн «Долоон самуурай» гэдэг киног сайн мэднэ. Уг кинонд 1600-гаад оны үйл явдал гардаг. Дээрээ феодалууд учраа олохгүй нанчилдаж байхад доогуур дээрэмчид хөдөө тосгодыг дээрэмдэн тонож байв. Энэ үед нэг тосгоныхон 7 самуурайг хөлслөн тосгоноо хамгаалдаг. Гэнэт дайснууд ирэхэд тосгоныхон айж балмагдан амиа хоохойлон нуугдаж байна. Энэ байдалд бухимдсан самуурай нар «Хэрэв та нар амиа бодох юм бол бүгд үхнэ. Харин бүгд бусдынхаа амь насыг хамгаалан тэмцсэн цагт өөрийн амийг аврах болно» гээд зоригжуулан хөдөлгөж дайснаа ялдаг. Энэ бол шинэ үеийн Японы ёс суртахууны гүн ухааныг хэлсэн хэрэг байв. Иймээс японучууд хүүхдийг сургахдаа нийтийн эрх ашгийг эрхэмлэх ёс суртахууны хүмүүжилд онцгой анхаарал тавьдаг байх юм. Тэгвэл орчин үеийн япон хүн энэ уламжлалыг бүрэн эзэмших төдийгүй, дээр нь хүнтэй еелдэг, хүндэтгэлтэй харилцах зан суртахуун, орчин үеийн өндөр боловсролыг эзэмшсэн байхыг чухалчилдаг. Тэдний хөгжлийн нууц нь ердөө л энэ.

Тэгвэл Хятадыг авч үзье. Хятад бол хүн ам олонтой өнөр айл. Тэнд сайн эцгийн зөв үлгэр дуурайл чухал. Эцэг хүний, удирдагч хүний, хятад хүний эрхэмлэвэл зохих ёс суртахууны хэм хэмжээг Күнзийн сургаалд заагаад өгчээ. Ийм ёс зүйг удирдлага болгон өнөөгийн Хятад орон босч ирж байна. Сүүлийн үед оросууд маш хүчтэй өндийн сэргэж байна. Оросын удирдагч В.Путин «орос хүний ёс суртахуун» гэгчийг гаргаж ирлээ. Уламжлалт орос хүний зан чанарыг бидний өмнөх үеийнхэн сайн мэднэ. Тусархуу, цагаан цайлган, хээ шаагүй гээд орос сайн нөхрийн тухай тэд хэлээд өгнө. Оросууд «Великий русский характер» гэдэг ёс суртахууны сургалтыг дунд сургуулийнхаа хичээлийн хөтөлбөрт аль хэлдийнэ оруулан хүүхэд залуусаа хүмүүжүүлж эхэлжээ. Харин Монголын удирдагчид ямар байдгийг бид мэднэ. Тэдний хуйвалдсан, дээрэмдсэн, залилсан, тэрбумаар идсэн уусан ёс зүйгүй үйлдлийг бид өдөр бүр халаглан хэлэлцэж байдаг. Одоогийн увайгүй ёс суртахуунтай, хөрөнгө мөнгөндөө сагасан хүмүүс улс оронд хөгжлийн том үсрэлт хийж чадахгүй гэдгийг дөнгөж л одооноос ярьж хэлдэг болж байна. Монгол Улсыг өндөр ёс суртахуунтай хүн л хөл дээр нь босгож, хөгжүүлж дэвжүүлж чадна. Тэгэхээр нийгмийн ёс суртахуун нь улс орны хөгжлийг тодорхойлох хамгийн чухал асуудал болж таарч байна.

Г. УЛАМЖЛАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Хуулийн хариуцлагаас ёс суртахууны хариуцлага илүү хүнд хатуу байдаг. Хуулийн хариуцлага хугацаатай. Хүн буруу хэрэг хийвэл шоронд хугацаатай явуулдаг. Ёс суртахууны хариуцлагад хугацаа гэж байхгүй. Тийм ч учраас монголчууд «нэр хугарахаар яс хугар» гэж маш мэргэн оноож хэлсэн байдаг. Энэ хүн муу хүн шүү, энэ хүн худалч, хулгайч хол яваарай гэж эцэг, эх нь үр хүүхэддээ захисан бол энэ нь тэр хүнд оноож буй ёс суртахууны хариуцлага юм. Эрдэнийн Субашидад «муу юм хичнээн олон боловч муу хүнээс илүү аюул гэж үгүй» гэдгийг сануулсан байх аж. Ёс суртахууны доройтол, ёс суртахууны ялзрал нийгэмд асар их аюултай гэдгийг бид одоо тод харж байна.

Хүн нийгмийн нэг бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд байнгын харилцаанд амьдардаг. Хүний амьдрах арга ухаан, аж төрөх ёс, оюун ухаан, мэдлэг цөм нийгмийн харилцааны явцад бүрэлдэн буй болдог төдийгүй ажил үйлс, авьяас чадвар, ааш араншин, төрх төлөв, хэл яриа, дуу хоолой, зүрх сэтгэлээрээ бие биедээ нөлөөлж байдаг. Өөрөөр хэлбэл, хүн байнга хэн нэгэнтэй харилцаж амьдардаг. Ингэж харилцахдаа ёс суртахууны тодорхой хэм хэмжээг баримталдаг. Гэхдээ эдгээр ёс суртахууны хэм хэмжээг хүн юуны өмнө гэр бүлийн харилцаанаас олж авдаг байна. Хүүхдийн хэн болох нь гэр бүлийн орчноос 70 хувь хамаардаг болохыг судлаачид тогтоожээ. Дээр үеэс монгол гэр бүл дугуй хананы дунд гэр бүлээрээ цайлж хооллон, унтаж амарч, эргэн тойрон болон айл саахалтад болж байгаа бүх л үйл явдлын мэдээ сэлтийг аав ээжийн ярианаас сонсон тэдний шүүн хэлэлцэх ярианаас юу нь болох, юу нь болохгүй вэ, аль нь сайн, муу болох зэргийг ялган салгаж ойлгож авах төдийгүй

жаахан том болоод өөрөө бясалган бодох, өөрийн үзэл бодлыг илэрхийлэх зэргээр хүмүүжлийн том сургуульд суралцдаг байжээ. Гэр бүлийн ийм орчинд хүүхдийн хүмүүжүүлэгч нь ээж аав, эмээ өвөө, эгч ах, ахмад хүмүүс байдаг байв. Ингэж хүүхэд бага балчраасаа эхлэн аав ээжийгээ даган тэдний үйл хөдлөл, үг яриа бүрээс өвлөн авч, амьдралд бэлтгэгдэх төдийгүй, уламжлалт зан заншил, хэл яриа, соёл зэрэг ухамсрын үндсэн элементүүдийг эзэмшиж, нийгмийн харилцаанд бэлтгэгддэг байна. Энэ үндсэн дээр зан араншин нь төлөвшдөг. Эх нь шийр алаг бол унага нь хээр алаг гэж ярьдаг. Эцэг, эх нь зөв харилцаатай, зөв үйлтэй, зөв хандлагатай бол хүүхэд нь мөн л зөв харилцаатай, зөв үйлтэй, зөв хандлагатай болж төлөвшдөг. Монголын эрт болон саяхны бидний сольж шинэчилсэн өмнөх нийгмийн гэр бүлийн хүмүүжлийн гол арга нь модон ханатай эсгий гэр доторх гэр бүлийн гишүүдийн үлгэрлэл байв. Хүүхэд өсч том болоод хөдөлмөрийн хамт олны дунд орж, амьдарч ахуй нийгэм, хүрээлэн буй орчинтойгоо зохицон амьдрах ухааныг олж, бусад хүмүүсийг танин мэдэж, тэдэнтэй харилцах ур чадварыг эзэмшиж, бие хүн болон төлөвшдөг.

Хараал зүхлээс өөр үг мэддэггүй, архи дарсанд живсэн, байнгын хэрүүл уруултай айлд хүүхэд ямар үлгэр олж авах нь ойлгомжтой. Нэг үгээр хэлбэл, гэр бүлд хувь хүн төлөвшиж, нийгмийн олон талт харилцааны суурь мэдлэгийг олж авдаг. Тухайн хувь хүн гэр бүлд хэрхэн төлөвшснөөсөө хамааран нийгмийн харилцаанд ороходоо ёс суртахууны төлөв байдал нь илэрдэг байх юм. Тухайлбал, гэр бүлийн гишүүдийн бие биеэ хүндэтгэх, асуудлыг сонсох, хүлээн авах, илэрхийлэх зан байдлын төлөв нь тэр гэр бүлийн орчин нөхцөлөөс шууд хамааралтай байх нь. Айлын ганц, хар багааса хошуу дэвсэж, хайраар өлгийдүүлж өссөн хүүхэд ямар хүн болох нь ойлгомжтой. Ийм хүүхэд хүнээс үг сонсдоггүй, үг даадаггүй, нялцгай нялзрай байдаг. Өнөө үед хүмүүсийн амьдрах орчин нөхцөл маш их өөрчлөгджээ. Олон өрөө тасалгаатай байшинд цөөн ам бүлээр суух болов. Аав нь өглөө эрт ажилдаа гараад харанхуй шөнөөр ирнэ. Ээж нь бас ажил гээд завгүй. Хүүхэд гэр бүлийн орчинд ээж ааваас үлгэр авч хүмүүжихээс илүүтэй хамт олон, найз нөхдийн хүрээлэлд илүү олон цагийг өнгөрөөх болжээ. Гэртээ ирээд ч тэд ээж, аавтайгаа халуун дулаан яриа өрнүүлж суухаас илүүтэй өөр өрөөнд ороод фейсбүүк «ухах», таблет, компьютер дээр янз бүрийн кино үзэж цагийг нөхцөөх болсон. Хүүхэдтэйгээ нээлттэй ярилцах, санаа бодлыг нь сонсох, зөвлөлдөх, сургах, үг хэлэх амьд харилцаа ийнхүү үгүй болов. XX зуун бол Монголд соёлын модернизацийг түргэвчилсэн хэлбэрээр хэрэгжүүлсэн буюу орос соёл гэгчийг нэвтрүүлсэн зуун байв. Дундад зууны харанхуй бүдүүлэг орноос орчин үеийн шинэ социалист маягийн аж төрөх ёс бүхий дэлхийн соёлжиж иргэншсэн нийгмийг байгуулж чадсан гэж социалист нийгмийн ололт амжилт болгон сайрхан бичиж байсан цаг саяхан. Гэхдээ ЗХУ-ын нөлөөгөөр социалист маягийн зээлдмэл соёлыг бий болгохдоо үзэл суртлын агуулгаа голлож, үндэсний соёлыг орхигдуулан гажуудуулсан тал бий. Ийнхүү 70 жил бид үндэсний уламжлал, ёс заншлаа хувьсгалт суртлаар сольж, шашин шүтлэг, сүм хийд, ном судраа устган, ёс заншил, уламжлалт, үндэсний гэсэн бүгдийн хуучны юм, феодалын ёс хэмээн адалж, гээж орхисон байна.

Д. ХҮМҮҮЖИЛ ДЭХ СОЁЛЫН НӨЛӨӨ

1990 оны ардчилсан хувьсгалын өөрчлөлтийн явцад коммунист үзэл суртлын үл гүйцэлдэх тоталитар, хүний эрх чөлөө, үзэл бодлыг хяхан хавчсан зэрэг олон согог гажгийг олж харсан төдийгүй, түүнийгээ ад үзэн хаяж гээгээд барууны либераль үзэл санааг шууд хуулбарлан авч хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, барууны соёл Монголд нэвтэрч, тэр нь соёлын гол цөмийг тодорхойлогч болох үйл явц өрнөж байна. Гэхдээ өрнөдийн гэсэн бүхнийг сайн гэж хэтийдэн дөвийлгөх нь бас л өрөөсгөл болно. Өөрийн уламжлалт өв соёлыг дэлхийн сонгодог өвтэй эн тэнцүүхэн байранд тавьснаар улс үндэсний өвөрмөц соёл оршин тогтнох учиртай.

Манай соёл иргэншлийн суурь нь нүүдлийн мал аж ахуй байсаар ирсэн. Хэдийгээр бид өмнөх үеэ харанхуй бүдүүлэг гэж хоч нэр өгдөг ч, энэ л нүүдэлчин ард түмэн уртын дуу, хөөмий, морин хуур гээд дэлхийд хосгүй уламжлалт соёл, байгалийн уянгыг дүрсэлсэн хээ угалз, сонгодог өвөрмөц уран сэтгэлгээ бүхий монгол зураг, түүнд түшиглэн хөгжсөн бурханы хөргийн урлаг, аман соёлын аугаа гайхамшиг болсон ерөөл магтаал, туульсын зохиолын дахин давтагдашгүй өвийг бүтээж чадсан билээ. Гэтэл бид энэ соёлоо ойлгох, үнэлэх, түгээх, хадгалах, бахдаж бахархах, залгамжлуулах талаар тун бага зүйл хийжээ. Монголын соёлын эдгээр хосгүй уламжлалаа бид нийтийн гэгдэх хямдхан соёл болох алиа наргиан, зугаа цэнгэлийн урлагаар сольсон байна.

Оюун санааны хүрэээнд шинэчлэл хийхдээ аль нэг эрхэмлэлийг туйлшран шүтэх нь үргэлж алдаа завхралд хүргэдэг гэдгийг судлаачид сануулжээ. Социализмын үед соёлын уламжлалаа адлан хаясан шиг, капиталист шинэтгэлийн үед хувийн эрх ашгаар бамбайлан

үнэт зүйл, уламжлалт соёл, ёс заншил, шударга ёсны уламжлалаа гээсэн түүх дахин давтагдаж болзошгүй байна. Бидний муу хэлээд байгаа өмнөх нийгэмд сонгодог урлаг, ардын дуу хөгжим, дүрслэх урлагийг бид дэлхийн төвшинд хүргэж чадсан гавьяа бий. Оросын хамгийн шилдэг сургуулиудад хүүхдүүдээ илгээн, дэлхийн энтэй балетчин, дуурийн дуучин, зураач, хөгжмийн зохиолч, архитекторуудыг бэлтгэсэн. Үүний ачаар бид Азид толгой цохих хэмжээний дуурь болоод бүжгэн жүжгийн театр, сонгодог урлагийн сургууль дэгтэй болсон. Бидний нэг үе энэ урлагаар хүмүүжиж, энэ урлагаар бахархаж явсан. Гэтэл эдүгээ сонгодог урлагаараа бахархах, залуучуудыг урлагаар хүмүүжүүлэх тухай хэн ч ярихгүй байна.

Сонгодог урлаг зах зээлийнхээ жамаар бүтээгдэхүүнээ худалдах үнэлүүлэх жамаар хөгжиж байна. Соёл урлаг ашиг арилжааны үйлдвэрлэл болж хөгжиж байна. Соёл урлаг бол хүнийг нийгэмшүүлэх гол үүрэгтэй. Гэтэл манайд цэнгүүлэх, зугаацуулах үүрэг нь давамгайлах болж. Шинэ хүнийг төлөвшүүлэн хүмүүжүүлэх учиртай урлаг, уран бүтээл ийм ядуухан агуулгатай, гүехэн утгатай байж таарахгүй. Дуу хөгжим гэхэд манай нэг нэртэй дуучны хэлснээр «мөнгө, гавьяат хоёрт хүрэхэд хамгийн дөт зам» болоод буй. Нэг ижил саарал хоолойтой хэдэн зуун дуучин өдөр бүр шахам концерт тоглолтдоо урьсаар. Хошин шог, шоу цэнгүүн, гоо бүсгүйн шалгаруулалт, рок поп хамтлаг, эстрад урлаг, стриптиз үзүүлбэр зэрэг хямд өнгөц урлагийн бүтээлээр ард түмнээ 30 жил аргацааж ирлээ. Хүнийг хүн болгох асар их нарийн утга учрыг өөртөө агуулсан бэлгэдэлт соёлоо өнгөц хийсвэр үнэгүй шахам соёлоор солих нь монгол хүнийг ахиад л «гаж хүн» болгоход тустай үйл болох юм. Чанартай чансаатай, сонгодог урлаг ард олонд хүртээмжгүй байна. Өнгөрсөн зууны 60-аад оны кинонуудыг одоо ч үзэхэд огт уйддаггүй. Гэтэл өнөөгийн шинэ үеийн киног нэг үзээд мартдаг. Садар самуун, аллага, хүчирхийлэл зэрэг өрнөдийн модернист хэвийг илүүтэй шүтсэн, агуулга хэлбэрийн хувьд тун ядмагхан болдог учраас тэр биз.

Хүмүүсийн ёс суртахуун хямралд орсон үед хүн хэт энгийн прагматик зүйлийг шүтэж, соёлын жинхэнэ бүтээлийг нийтийн соёл хэмээх соёлын «оронцогууд» орлодог байна. Эдгээр нийтийн соёл гэдэг нь хүний зан авирыг улам дордуулж эвдэж байдаг хүчирхийлэл, аллага хядлага, садар самууныг эрээ цээргүй сурталчилдаг, нийгэмд айдас түгшүүр, гутрал төрүүлэх зүйлээр дүүрэн байдаг. Барууны соёл нь зөвлөлт маягийн соёлоос ялгаатай нь гаднаас тулган хүлээлгэхээсээ илүүтэй бидний хувьд даган дуурайх, түүнд сайн дураар автах шинжтэй байгааг судлаачид онцолсон байна. Гар утас, компьютерийн үсрэнгүй хөгжил нь техникийн эрин үеийн ололт мөн. Тэрэнгүйгээр бид цааш хөгжих аргагүй нэг хүчин зүйл болсон нь ч үнэн. Гэхдээ энэ бүгд хүүхэд залуучуудад маань ямар эерэг болоод сөрөг нөлөөг үзүүлж байгааг судлах, ойлгуулах шаардлага бий. Монгол хүүхдүүд автобусанд ч, гэр орондоо ч байнга чихэвч зүүж явдаг болсон. Үүнийг бид байх л ёстой зүйл мэт бүр дасжээ. Гар утсыг гадаад хэл сурах, шинэ мэдээлэл авах, үзсэн хичээл номоо бататгах зэрэгт ашигладаг хүнд юутай ч зүйрлэшгүй боломж юм. Гэтэл ийм зорилгоор утас «мааждаг» нь хэд билээ. Чихэвчээр үргэлж хөгжим сонсож явсаар нэг талаар сонсгол муудах эрсдэлд орж, нөгөө талаар харийн соёлыг хэт шүтэх, дөвийлгөх, монгол дуу хөгжим, ардынхаа урт, богино дуу, эгшиглэнт сайхан морин хуур хөгжмөө хүртэл адлах болов.

Монгол залуучуудын хүмүүжил, ёс зүйд гадны дуу хөгжим, киногоор дамжин гадны соёлын зөөлөн хүчний нөлөө маш хүчтэй нэвтэрч байна. Ганцхан жишээ хэлье. Манайд Солонгосын олон ангит кино үзүүлдэггүй телевизийн суваг гэж бараг алга. Хаашаа л суваг эргүүлнэ ямар нэг солонгос кино гарч байдаг. Үүгээр дамжуулан монгол залуучууд солонгос соёлын нөлөөнд автаж, тэдний үйл хөдлөл, өмсөж зүүхээс эхлээд хэл яриа, хоол унд, гадна төрх хүртэл солонгос хэв маягт уусч байгааг анзаарахгүй байх арга алга. Гадны соёл, тэдний хоол хүнс, амьдрах хэв шинжийг хэт дуурайн автсаны нөлөөг тусгайлан судалж шинжлэх шаардлага ч гарч байна.

АШИГЛАСАН НОМЫН ЖАГСААЛТ:

- Баярмаа С. Ардчилсан шилжилтийн үеийн Монголын улс төрийн соёлын төлөвшил /Магистрын ажил/. УБ., 2004.
- Вандангомбо Р. Захиргааны ёс зүй. УБ., 2013.
- Ганхуяг Д. Хошуучлагчийн улс төрийн имиж, түүнийг бүрэлдүүлэхүй. УБ., 2004.
- Золзаяа М. Ёс зүй. УБ., 2005.
- Тунгалаг Д. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ., 2007.
- Цэнд-Аюуш Г. XIX-XX зууны улс төрийн сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм. УБ., 2015.

Citi University Sports Hall was opened in September 2017 and has a total capacity of 600 people and an area of 15x28 meters.

Our gym meets the standards of the International Basketball Federation, and it has 6 layered “A” graded flooring.

Citi University SPORTS HALL



https://www.citi.edu.mn/en/citisport/

Б.МӨНХТОГТОХ
«СИТИ» Их сургуулийн Бизнесийн сургуулийн
Аялал жуулчлалын багш, магистр

Х.ОЮУНДАРЬ
«СИТИ» Их сургуулийн Бизнесийн сургуулийн Аялал
жуулчлалын тэнхимийн IV курсийн оюутан

ЖУУЛЧНЫ БААЗУУДЫН УСНЫ ХЭРЭГЛЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ
(Тогтвортой аялал жуулчлалын судалгааны жишээн дээр)

Хураангуй

Аялал жуулчлалын салбарын усны хэрэглээ нь орон нутгийн уугуул иргэдийн амьжиргаа, экосистемд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагатай юм. Үүний тулд аялал жуулчлалын зорилгоор ашигладаг усны хэрэглээний экосистемд үзүүлж буй нөлөөлөлд мониторинг хийж, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний байгууллагуудын усны менежментийн зорилтуудыг тодорхойлох хэрэгтэй байна.

Монгол Улсын жуулчны баазуудын усны хэрэглээ, нэг жуулчинд ногдох хэмжээг Тогтвортой аялал жуулчлал ба Монгол дахь хэрэгжилт судалгааны экспедицийн 2019 онд хийсэн судалгааг ашиглан Монгол Улсын хүн амын хэрэглээтэй харьцуулан судалсан болно. Ийнхүү судлахдаа 6-9 сард идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, 5 аймаг дахь 10 жуулчны баазын 1 оронд ногдох усны хэрэглээг тодорхойлж, Улаанбаатар хот, хөдөө орон нутгийн иргэдийн хоногийн усны хэмжээтэй харьцуулсан бөгөөд жуулчны баазуудын ус ашиглалтыг харуулсан болно.

Түлхүүр үгс

Тогтвортой хөгжил, саарал ус, аялал жуулчлалын бааз

А. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Тогтвортой хөгжил нь өнөө үеийн хэрэгцээг хангахдаа дараа үеийнхний хэрэгцээ, боломжийг хязгаарлахгүй байхад оршино[1]. Тогтвортой хөгжлийн зорилт нь Мянганы хөгжлийн зорилтын үргэлжлэл бөгөөд хоорондоо харилцан хамааралтай тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт нь хэнийг ч орхигдуулалгүй, ядуурлын бүх хэлбэрийг устгаж, эх дэлхийгээ хамгаалах, хүн төрөлхтнийг тайван амгалан, хангалуун, эрх тэгш амьдрах боломжоор хангах дэлхий нийтийн зорилго юм. Тогтвортой хөгжил нь судалгааны явцад улам бүр нарийсч, эдийн засаг ба үйлдвэрлэл, нийгэм-соёлын бүхий л хүрээнд тухайн салбарын хөгжлийн чиг хандлагаар тодорхойлогдох болжээ. Эрдэмтэд өөр өөрсдийн судалгааны салбарт тогтвортой хөгжил гэж чухам юу байх, түүнийг хэрхэн томьёолох, ямар арга замаар түүнд хүрэх талаар судалгаа явуулах болсон бөгөөд энэ үеэс аялал жуулчлалын салбарын судлаач эрдэмтэд ч тогтвортой аялал жуулчлалын талаар нарийвчлан судалж эхэлсэн.

Зураг 1. Тогтвортой аялал жуулчлалын загварын схем



Дээрх загвараас харахад тогтвортой аялал жуулчлалын хөгжил нь энэхүү үйл ажиллагаанд оролцогч гол субьектуудын эрх ашгийн нийцтэй давхцал дээр бий болно гэж үзэж болохоор байна. Тодруулбал, аялал жуулчлал эрхлэгч бизнесийн байгууллагууд тухайн орон нутгийн нөөцийг ашиглах замаар эдийн засгийн ашиг, орлого олох зорилготой. Харин Байгаль орчны яамаар төлөөлүүлсэн төрийн захиргааны байгууллагуудын үндсэн зорилго нь нөөцийг хамгаалахад оршино. Тэгвэл орон нутгийн иргэд өөрийн нутаг орныг эзэмших, нөөцөө ашиглах, үр шимийг нь хүртэх зорилготой. Аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогч эхний хоёр субьектын эрх ашиг, сонирхлын давхцал бол байгалийн аялал жуулчлал буюу байгальд түшиглэсэн, байгальд элгэмсэг аялал жуулчлалын хөгжлөөр илэрч байхад аялал жуулчлал эрхлэгчид ба орон нутгийн иргэдийн эрх ашгийн давхцал нь тэдний харилцан ашигтай аялал жуулчлалын үйл ажиллагаагаар илэрнэ. Энэ нь тухайн орон нутагт хөгжиж буй аялал жуулчлал нь орон нутгийн болон иргэдийн ахуй амьдралыг дэмжиж, эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгэм – соёлд нь сөргөөр нөлөөлөхгүйгээр хөгжих ёстойг харуулж байна. Харин орон нутгийн иргэд хийгээд төрийн захиргааны аппаратын эрх ашгийн давхцал нь нөөц ашиглалтын зөв бодлого, менежментээр

хэрэгжих ёстой. Энэ хамаарлыг хамгийн зөвөөр удирдах ёстой гэсэн үг юм.

Монгол Улс усны нөөц багатай орны тоонд багтдаг бөгөөд байгаа багахан нөөц нь нутаг дэвсгэртээ жигд бус тархсан, хяналт, менежмент сул, эрх зүйн орчин нь боловсронгуй бус, ус хангамжийн түвшин доогуур, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн хүртээмж, хүчин чадал дорой, хүний нөөцийн хомсдолтой байна. Нөгөөтэйгүүр, Монгол оронд нүүрлэж байгаа уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, түүнээс үүдсэн цөлжилт идэвхжиж хүрээгээ тэлж байгаа нөхцөлд түүний сөрөг нөлөөг зөөлрүүлэх, байгалийн нөөцийг хадгалах, амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх оновчтой хэлбэрийг тогтоох, эдийн засгийн тогтвортой өсөлт, тухтай амьдралын хэрэгцээг хангах шаардлагатай байна. Дээр дурдсан шаардлагууд усны асуудлыг улс үндэстний ирээдүйн хөгжил, дэвшилтэй нягт уялдаатайгаар шинэлэг байдлаар авч үзэх нэг үндэслэл болж байна.

Монгол орны нутагт бүрэлдэх гол, мөрний усны жилийн дундаж нөөц 30.6 шоо км, ОХУ, БНХАУ-ын нутгаас ирэх урсацыг оролцуулан тооцвол 34.6 шоо км болно. Гол мөрний бүх усны нөөцийн 49.0 хувийг /16.9 шоо км/ Хойт мөсөн далайн ай сав, 11 хувийг /3.80 шоо км/ Номхон далайн ай сав, 40 хувийг /13.9 шоо км/ Төв Азийн гадагш урсацгүй ай савын гол горхины урсац эзэлнэ. Монгол Улс газар нутгийн байршлаараа усны гурван том хагалбарын заагт, харьцангуй өндөрлөг, Ази-Номхон далайн бүс нутгийн хамгийн хур тунадас багатай, хуурайшилт ихтэй хэсэгт оршдог. Усны нөөц нь нутаг дэвсгэрийн хувьд жигд бус тархалттай, зарим бүсийн усны чанар эрүүл ахуйн шаардлага хангадаггүйгээс гадна гол мөрний ус нь ихэнхдээ тус улсын хилээс гадагш урсдагаас шалтгаалан усны нөөц бага, хязгаарлагдмал орны тоонд ордог.

Гол мөрний жилийн дундаж урсацын 60 хувь нь гадагш хил даван урсаж, үлдэх хувь нь хөрсөнд нэвчиж, газрын доорх усыг тэжээх буюу говийн нууруудад цутгана. Усны нөөцийн 83.7 хувийг нуур, 10.5 хувийг мөсөн гол, 5.8 хувийг голын ус тус тус эзэлнэ. Гадаргын усны нөөцийн 85 хувийг цэнгэг ус, түүний 93.6 хувийг Хөвсгөл нуурын ус эзэлдэг. Газрын доорх усны нөөц асар их хэмжээтэй боловч удаан хугацаанд нөхөн сэлбэгддэг учраас ашиглаж болох нөөцийн хэмжээ тун бага байдаг бол гадаргын ус буюу голын ус богино хугацаанд /20 хоногт/ буюу жилдээ 18 удаа солигддог ажээ. Манай улс ус хэрэглээнийхээ 90 орчим хувийг газрын доорх усаар хангадаг байна. Газрын доорх ус нь экологийн нэн эмзэг тогтоцтой, усны горим тэжээлийн систем нь өөрмөц, нөхөн сэргэх хугацаа нь хэдэн арав, хэдэн зуун жилээр тооцогддог учраас газрын доорх усыг онцгой хамгаалалтад авч нөхөн сэлбэгдэх хэмжээнээс үл хэтрүүлэн ашиглах шаардлагатай байдаг.

Нийт хүн амын 30.5 хувь нь төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс, 35.8 хувь нь зөөврийн ус тээврийн үйлчилгээнээс, 24.6 хувь нь ус түгээх байр, худгаас, 9.1 хувь нь булаг, шанд, гол горхиноос усаа авч хэрэглэж байна. Усны хэрэглээний түвшин нь харилцан адилгүй бөгөөд хот, суурин газрын инженерийн хангамж бүхий орон сууцанд оршин суугчид хоногт дунджаар 230-350 литр, хөдөө орон нутаг болон гэр хороололд оршин суугчид дунджаар 5-10 литр ус хэрэглэдэг. Ус ашиглалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд цаашид хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын хүртээмжийг сайжруулах, мал аж ахуй, газар тариалангийн тогтвортой байдлыг хангах, бэлчээр, газар тариалангийн талбайг усжуулах, хөнгөн, хүнс, уул уурхайн болон бусад үйлдвэрлэлийн салбар, сэргээгдэх эрчим хүчний салбаруудын хөгжлийг тодорхойлох үндсэн дэд бүтцийн нэг, хөгжлийн голлох хүчин зүйл болж байна.

Б. ЖУУЛЧНЫ БААЗЫН УСНЫ ХЭРЭГЛЭЭ


Аялал жуулчлалын салбарын эрчимтэй өсөлт нь орон нутгийн эдийн засагт хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлт зэргээр олон талын ач холбогдолтой хэдий ч хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлдэг тал бий. Монгол Улсын хувьд 300-1500 мм хур тунадасны ууршилттай бүс нутаг, гадаргын гүний ус нийт усны 2 хувийг эзэлдэг. Гэтэл жуулчны баазууд ихэвчлэн газрын гүний усыг ашигладаг. Гүний усны нөөц бага, нөхөн сэргээгдэх хугацаа их, нутгийн ихэнх хэсэг нь ууршилттай гэдэг нь дараах зургаас харагдаж байна. Гүний ус ихэнхдээ хур борооны ус болон цасны усаар тэжээгддэг. Нутгийн өмнөд хэсгийн ихэнх хэсэгт жилд ордог хур тунадасны хэмжээ 60-200 мм буюу маш бага учир нөхөн сэргээгдэх боломж хомс байдаг.

Хүснэгт 1. Жуулчны баазуудын усны хэрэглээний судалгаа

№	Жуулчны баазууд	Хоногт хэрэглэх усны хэмжээ /литрээр/	Нийт орны тоо	Нэг оронд ноогдох цэвэр усны хэрэглээ хэмжээ	Нийт аялал жуулчлалын улиралд хэрэглэгдэх усны нийт хэмжээ	
1	Баянговь	8000	150	53	150	1200000
2	Батхаан	2000	30	67	120	240000
3	Дэлгэр	300	28	11	120	36000
4	Монгол-Алтай тур	2000	100	20	150	300000
5	Хатан- Өгий	1000	44	23	120	120000
6	Тайхар	3000	60	50	120	360000
7	Чулуут tour	2500	36	69	120	300000
8	Хантайга	4000	50	80	120	48000
9	Анар	6000	100	60	120	720000
10	Хангарьд	1000	80	13	120	120000
Бүгд		29800	678	446	1260	3444000

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас «нэг жуулчинд /ор, эсвэл хоног байж болно/ ногдох ус ба эрчим хүчний хэрэглээний үзүүлэлтийг байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээг хэмжих гол үзүүлэлтээр тодорхойлсон байна . Эдгээр жуулчны бааз нь ажиллах хугацаандаа нийт 3 сая 444 тонн усыг ашиглаж байгаа нь усны хэрэглээ зохисгүй түвшинд байгааг харуулж байна.

График 1. Усны хэрэглээний харьцуулалт



Судалгааны дүнгээс үзэхэд жуулчны баазын хоногт хэрэглэх усны дундаж хэрэглээ нь 44.6 литр буюу Улаанбаатар хотын орон сууцны усны хэрэглээнээс 12.7 хувиар бага, Улаанбаатар хотын гэр хороолол болон хөдөө орон нутгийн иргэдээс 4.6 дахин их байна.

Хүснэгт 2. Жуулчны баазуудын 1 удаа хүлээн авах хүчин чадал

№	Жуулчны баазууд	1 удаа хүлээн авах хүчин чадал					
		Гэрийн тоо	Нийт орны тоо	Рестораны суудал	Жорлон	Шүршүүр	Саун Бассейн
1	Баянговь	48	150	100	8	4	
2	Батхаан	15	30	20	4	4	
3	Дэлгэр	14	28	28	4		
4	Монгол Алтай тур	32	100	100	11	12	
5	Хатан Өгий	11	44	50	6	4	2
6	Анар	45	100	100	16	16	
7	Тайхар	17	60	40	4	4	
8	Чулуут тур	9	36	30	6		
9	Хан тайга	11	50	40	4	2	1
10	Хан гарьд	26	80	70			
Бүгд		228	678	578	63	46	3

Дээрх жуулчны баазуудын нийт орны тоо 678 бөгөөд 302.3 тонн усыг хоногт хэрэглэдэг гэсэн судалгаа гарч байна. Гүний усны усны нөөц багатай манай орны хувьд гүнээс их ус авч хэрэглэж байгаа нь цаашлаад орон нутгийн иргэдийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх магадлалтай байна.

Хүснэгт 3. Жуулчны баазын ажиллах хугацаа

№	Жуулчны баазууд	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Ажиллах хугацаа
1	Баянговь	*	1	1	1	1	1	*	*	*	5
2	Батхаан	*	*	1	1	1	1	*	*	*	4
3	Дэлгэр			1	1	1	1	*	*	*	4
4	Монгол Алтай тур		1	1	1	1	1	*	*	*	5
5	Хатан Өгий			1	1	1	1	*	*	*	4
6	Анар			1	1	1	1	*	*	*	4
7	Тайхар			1	1	1	1	*	*	*	4
8	Чулуут тур			1	1	1	1	*	*	*	4
9	Хантайга			1	1	1	1	*	*	*	4
11	Хангарьд			1	1	1	1	*	*	*	4
Бүгд			2	10	10	10	10				

Хүснэгт 4.Усны гадаргын ууршилт /мм/

№	Аймаг	Сум	Жуулчны бааз	Усны гадаргын ууршилтын хэмжээ/мм/
1	Архангай	Өгийнуур	Хатан-өгий	700-900
2	Архангай	Их-Тамир	Тайхар	700-900
3	Архангай	Чулуут	Чулуут тур	700-900
4	Булган	Рашаант	Монгол-Алтай тур	500-700
5	Өвөрхангай	Бүрд	Баянговь	700-900
6	Өвөрхангай	Хархорин	Анар	700-900
7	Төв	Жаргалант	Дэлгэр тур	500-700
8	Төв	Эрдэнэ	Батхаан	500-700
9	Хөвсгөл	Хөвсгөл нуурын доод буланд	Хан гарьд	300-500
10	Хөвсгөл		Хан тайга	300-500

Хүснэгт 5. Усны гадаргын ууршилтын хэмжээг бүс нутгаар ангилах нь:

№	Ууршилтын хэмжээ/мм/	Аймаг	Жуулчны баазын тоо
1	300-500	Хөвсгөл	2
2	500-700	Булган	1
		Төв	2
		Хөвсгөл	2
3	700-900	Архангай	3
		Өвөрхангай	2

Дээрх бүс нутгуудад ууршилтын хэмжээ их, хур тундасны хэмжээ нь газрын гүний усыг нөхөх хэмжээнд хүр чаддаггүй учир гүний усыг гамтай хэрэглэх шаардлагатай юм.

В. ҮР ДҮН

Аялал жуулчлалын нөөц гэдэг нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үндсэн орчныг бүрдүүлж байгаа элементүүдийн цогц юм. Тодруулбал, жуулчны баазын үйл ажиллагаанд усан хангамж ба эрчим хүчний найдвартай эх үүсвэр хамгийн чухал бөгөөд тухайн газар нутгийн усны болон эрчим хүчний нөөц, хангамж нь жуулчны баазын хувьд аялал жуулчлалын чухал нөөц болно.

Тиймээс бид тухайн жуулчны баазын өдөрт хэрэглэдэг цэвэр усны хэмжээг орны хүчин чадалтай нь харьцуулах замаар нэг жуулчинд /оронд/ ногдох цэвэр усны хэрэглээний хэмжээг тооцож гаргалаа. Нэг оронд ногдох усны хэрэглээний хувьд судалгаанд хамрагдсан жуулчны баазууд нь харилцан адилгүй байна. Тухайлбал, нэг жуулчинд ногдох цэвэр усны хэмжээ авч үзье. Хангарьд /13 литр/, Дэлгэр /11 литр/, Чулуут тур /69 литр/ байна. Эдгээр нь харьцангуй бага хүчин чадалтай, эсвэл усны хэрэглээний төрөл цөөхөн жуулчны баазуудад юм. Харин Хатан-өгий /23 литр/, Хантайга /69 литр/ зэрэг байгаа нь усыг ариун цэврийн байгууламж ба гал тогоонд ашиглахаас гадна халаалтын шугам, усан бассейн болон бусад байгууламжуудад ашигладагтай холбоотой юм. Ийм газруудад усны хэрэглээний түвшин өндөр байна.

Судалгаанд хамрагдсан жуулчны баазуудад жуулчны нэг оронд ногдох усны дундаж хэрэглээ 44.6 литр байгааг дээр хэлсэн. Жуулчны баазын цэвэр усны хэрэглээ нь үндсэндээ ариун цэврийн байгууламж, гал тогоо хоёрт төвлөрдөг. Харин цөөн баазын хувьд усан бассейн, ариутга татуурга гэх мэт цэвэр ус хэрэглэдэг байгууламжуудтай байгаа юм.

ДҮГНЭЛТ


1. Усны хэрэглээгээ хянаж, бууруулж байгаа жуулчны баазуудын үйл ажиллагааг төрөөс дэмжих, чиглэсэн удирдамжаар хангах, усны эрсдэлийг тогтмол үнэлэх хөтөлбөртэй байх, усны эрсдэл өндөр үнэлэгдсэн тохиолдолд усны менежментийн зорилтыг мөрдүүлэх, хэрэгжилтийг нийтэд мэдээлэх зэрэг цогц арга хэмжээ хэрэгтэй байна;

2. Аялал жуулчлалын зорилгоор ашигладаг усны хэрэглээний экосистем болон нутгийн уугуул иргэдэд үзүүлж буй нөлөөлөлд мониторинг тогтмол хийх, аялал жуулчлалын байгууллагууд усны талаар тавьсан зорилтыг хэрэгжүүлж буй эсэхийг шалгаж сурталчлах, аялагчдад усны эрсдэл болон хэрэглээг багасгах талаар хүргэх мэдээллийг тогтмолжуулах шаардлагатай байна;

3. Судалгаанд хамрагдсан зочид буудал, жуулчны баазуудад усыг дахин боловсруулж, ашиглахтай холбогдсон ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаг талаарх мэдээлэл байхгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Тогтвортой хөгжлийн чиг хандлагад нийцсэн усны ухаалаг хэрэглээг бий болгох шаардлага нэгэнт бий болжээ.



АШИГЛАСАН НОМЫН ЖАГСААЛТ

I. Монгол эх сурвалж

- Баатарцоож. Г. Тогтвортой аялал жуулчлал. УБ., 2005.
- Баатарцоож. Г. Тогтвортой аялал жуулчлалын үзүүлэлтүүд ба Монгол дахь хэрэгжилт. УБ., 2004.
- Баатарцоож.Г. Жуулчны баазуудын тогтвортой хөгжлийн асуудалд. Эрдэм шинжилгээний хурлын илтгэл. УБ., 2005.
- Гансүх. Д. Хөдөөгийн аялал жуулчлалын үндэс. УБ., 2004.
- Монгол Улсын үндэсний атлас. 2009.
- Монгол Улс Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны дэд бүтцийг хөгжүүлэх суурь судалгаа-2021
- Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн сан https://www.1212.mn/
- Монгол Улсын стандарт Саарал усны систем MNS BS 8525-1 : 2015
- Монгол Улс Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны дэд бүтцийг хөгжүүлэх суурь судалгаа-2021
- Эрхзүйн мэдээллийн нэгдсэн сан https://legalinfo.mn/mn/detail/12652
- «Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр https://sdg.1212.mn/Home/Index
- Тогтвортой хөгжлийн үзүүлэлтийн систем, Нью-Йорк. 1996.

II. Гадаад эх сурвалж

- Earth Council. Agenda 21 for the Travel and Tourism Industry. 1992.
- Roberts L. and Hall D. Rural Tourism and Recreation. Principles to Pracitce. CABI Publishing. Oxon., UK. 2001.
- MNS ISO 14050:2003
- Indicators for the Sustainable Management of Tourism. Report of the International Working Group. W.T.O., IISD and ISTC.





СИТИ ИХ СУРГУУЛЬ

Денверийн гудамж, 7 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол

+976 77442244 www.citi.edu.mn info@citi.edu.mn /citiuniversity /Citi_University